



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ЖИЛИЙН ТАЙЛАН

2017

АГУУЛГА

ӨМНӨТГӨЛ.....	4
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР	
Хүний эрх.....	8
Эрх зүйн шинэчлэл.....	12
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь.....	15
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь.....	21
Сонгууль, улс төрийн санхүүжилт.....	25
Төрийн ил тод хариуцлагатай байдал.....	29
Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм.....	29
Иргэний нийгмийн байгууллагуудын тогтвортой үйл ажиллагааг дэмжих нь.....	32
Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь.....	33
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР	
Олборлох салбарын засаглал.....	40
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо.....	52
Бизнесийн орчин.....	62
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР	
Тэгш хамруулах боловсрол.....	66
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь.....	70
САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	75

ТОВЧИЛСОН ҮГ

АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АТГ	Авлигатай тэмцэх газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗХШХШТХ	Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ДӨЧИ	Дэлхийн өрсөлдөх чадварын индекс
ДЭЗФ	Дэлхийн Эдийн Засгийн Форум
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МҮОНРТ	Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОНХАГ	Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ
ОҮИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТАН эвсэл	Төлсөн Авснаа Нийтэл
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ХЭФ	Хүний эрхийн форум
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УДЭТ	Улсын Драмын Эрдмийн Театр
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл

Ардчиллын үр дүнд иргэд төрөөс шударга ёсыг шаардах эрх чөлөө олж авсан ч энэхүү шударга ёсыг хэрэгжүүлэхэд авлига гол саад тотгор болж буйг дэлхийн өнцөг булан бүрт төрийн өндөр албан тушаалтнуудын холбогдсон авлигын дуулиан харуулна. Иймээс авлигыг хяналтад оруулах нь ардчилсан хөгжлийн амин чухал эрх ашиг, түүний маш чухал үе шат гэж дэлхий нийтээрээ үзэх болжээ. Энэ нь манай улсын хувьд ч нэн тулгамдсан асуудал болж байна. 90-ээд оноос эхэлсэн нийтийн асар их баялаг тэр тусмаа төрийн өмч, газар, газрын доорх баялаг хувьчлагдах үйл явц тэр бүр шударга байж чадсангүй. Улам бүр өсөн нэмэгдэж буй төсвийн хөрөнгө ч үр ашигтай зарцуулагдахгүй байна. Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг хангах эрх зүйн шинэ орчин бүрдүүлэх чиглэлээр зарим чухал хууль батлагдсан ч бодит үр дүн төдийлөн гарсангүй. Эдгээр хуулийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг, оролцоо хангалтгүй, нөгөө талаас хэрэгжилтэд тавих хяналт сул, хуульд туссан хариуцлагын

механизмууд үр нөлөө муутайн улмаас бараг л хэрэгжихгүй шахам байна.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан 2017 онд Нээлттэй Нийгэм Форум төрийн ил тод, хариуцлагатай байдал, иргэдийн оролцоог дээшлүүлэх чиглэлээр шинээр батлагдсан хуулиудыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн оролцоог хангах чиглэлд илүүтэй анхаарч ажиллалаа. Бидний дэмжлэгтэйгээр 60 гаруй иргэний нийгмийн байгууллага бүх аймаг, дүүргийг хамруулан Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд мониторинг хийлээ. 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон хэдий ч хэрэгжихгүй байгаа Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу нийтийн сонсгол зохион байгуулах сонирхолтой иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн төлөөлөгчдийн хуралд арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлээ. Үүний үр дүнд орон нутагт нийтийн эрх ашгийн тулгамдсан асуудлаар Нийтийн сонсгол хийгдэж эхлээд байна. Төрийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд нэн чухал

үүрэгтэй Захиргааны шүүхэд нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах шинээр бий болсон механизмыг үр нөлөөтэй ашиглахад нь иргэний нийгмийн байгууллагуудад зориулан сургалт зохион байгуулж, тодорхой нэхэмжлэлүүдийг дэмжин ажиллалаа.

Улс төрийн санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдал өндөр түвшний авлигыг өөгшүүлж, газар авхуулж байгааг авлигын олон хэрэг харуулж байна. Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийг ил тод болгох чиглэлээр “Шударга сонгуулийн төлөө” иргэний нийгмийн сүлжээ сүүлийн хэдэн жил тууштай ажиллаж буй ч нааштай өөрчлөлт гарахгүй хэвээр байв. Харин 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тайланг ил тод болгох талаар төрийн хяналтын байгууллагуудад хуулийн хүрээнд шахалт үзүүлж ажилласны үр дүнд анх удаа сонгуульд нэр дэвшигчдийн санхүүжилтийн тайлан олон нийтэд хүрэх боломж бүрдээд байна. Сонгуулийн ерөнхий хороо болон Үндэсний аудитын газар нэр дэвшигчдийн санхүүжилтийн

мэдээллийг ил болгох хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаатай холбогдох гомдлыг иргэний нийгмийн байгууллагууд Хүний эрхийн Үндэсний комисст хандаж гаргасныг нааштай шийдвэрлэлээ.

Авлигын хамгийн эрсдэлтэй салбарын нэг нь уул уурхайн үйл ажиллагаа болоод байна. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах чиглэлээр 2004 оноос эхлэн ажилласан манай байгууллагын хувьд 2017 он уул уурхайн салбарт хийгдэж буй гэрээнүүдийг ил тод болгоход чухал жил боллоо. УУХҮЯ-тай хамтран үндэсний болон орон нутгийн түвшинд хийгдсэн бүхий л гэрээг ил тод болгох www.iltodgerее.mn вэб сайт ашиглалтад оруулж гэрээнүүдийг байршуулж эхлээд байна. Тэрчлэн, уул уурхайн салбарт ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийг ил тод болгох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд шаардлагатай бодлогын судалгаа, шинжилгээ хийж, оролцогч талуудыг хамарсан цуврал хэлэлцүүлэг явуулсны үр дүнд ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийг тодорхойлох, ил тод болгох асуудлаар талууд зөвшилцөлд хүрч, улмаар 2020 он хүртэлх үндэсний төлөвлөгөө батлагдлаа.

2017 онд бид шинээр хэрэгжиж буй хуулиудын хэрэгжилтэд шинжилгээ, мониторинг хийх үндсэн дээр бодлогын зөвлөмжүүд боловсруулан холбогдох төрийн байгууллагуудад хүргэж ирлээ. Мөн батлагдсан хуулийг олон

нийтэд таниулах, хэрэгжилтэд мониторинг хийхэд иргэний нийгмийнхэн идэвхийлэн ажиллаж байна. Хууль сахиулах салбарын зарим үйл ажиллагаанд мониторинг хийх чадавх бүхий 100 орчим иргэний нийгмийн байгууллага ажиллаж байгааг тэмдэглэхэд таатай байна.

Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд бие даасан судалгааны байгууллага, эрдэмтдийн судалгаа шинжилгээ, баримт нотолгоонд суурилсан хөндлөнгийн оролцоо чухал байна. Иймээс бид шүүхийн зарим шийдвэрийн үндэслэлд дүн шинжилгээ хийх судалгааны байгууллагуудтай хамтран ажиллаж үр дүнгээ гаргаад байна. Тэрчлэн, төрийн хууль тогтоомж, шийдвэрүүдийг иргэд амьдралдаа үр дүнтэй ашиглах, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэхэд нь туслахуйц эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө, холбон зуучлах анхан шатны нэг цэгийн үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн www-e-khutuch.mn сайтыг Хууль Зүйн Үндэсний Хүрээлэнтэй хамтран боловсрууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш хамрагдах эрхийг баталгаажуулахад нэн чухал үүрэг гүйцэтгэж буй эцэг эхчүүдийн холбоо, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг институцийнх нь хувьд чадавхжуулахад санхүүгийн болон мэргэжлийн туслалцаа үзүүлж ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг хангах Үндэсний хөтөлбөр боловсруулахад иргэний нийгмийн байгууллагууд тулгамдаж буй асуудлаар тодорхой санал оруулсны үр дүнд зарим шинэлэг, дэвшилтэт зүйл заалтууд хуульд тусгагдлаа. Ийнхүү сүүлийн 3 жилд төрийн бус байгууллагууд тасралтгүй хүчин чармайлт гаргаж ажилласны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах зарчим төрийн бодлого болж хуульчлагдлаа. Үүнээс гадна өсвөр насны хүүхэд, залуучуудын дундах хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх, дотоодын мэдлэг чадавхыг бий болгохоор нийгмийн ажилтан бэлтгэдэг их дээд сургуулиуд, хэвлэл мэдээллийн болон хүүхэд хамгааллын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Ийнхүү бид 2017 оны үйл ажиллагаагаа товчлон багцалж энэхүү тайланг Таны гарт хүргэж байгаадаа баяртай байна. Тайлантай холбоотой аливаа асуудлаар санал бодлоо хуваалцах аваас бид таатай хүлээн авах болно. Манай үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn сайтаас үзнэ үү.

*Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал*



ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР

2017 ОНД

80 гаруй арга хэмжээ зохион
байгуулж **2800** орчим хүн
оролцжээ.



ХҮНИЙ ЭРХ

Монгол Улс дахь хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах, иргэдийн хүний эрхийн боловсрол, мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр Нээлттэй Нийгэм Форум (ННФ) иргэний нийгэм, олон улсын байгууллагуудтай хамтран тодорхой ажлууд хийсээр ирлээ. Үүний дотор Монголын Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын Форум (ХЭФ)-ыг чадавхжуулахад анхааран ажиллаж байгаа бөгөөд өнгөрсөн онд ХЭФ

нь институцийн хувьд бэхжих алхмаа тавьж, хүний эрхийн салбарт өөрийн орон зайгаа бататгаж ажиллалаа. Мөн ХЭФ-тай хамтран НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг”-ээс авсан зөвлөмжийн дунд хугацааны тайлан бэлтгэх ажлыг эхлүүлж, НҮБ-ын хүний эрхийн механизмыг үр нөлөөтэй ашиглах чиглэлээр тодорхой ажлууд хийлээ.



▲ Олон Улсын Хүний эрхийн өдрийг тохиолдуулан Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд зохион байгуулсан “Хэнийг ч орхилгүй хөгжье!” олон нийтийн цуглаан, 2017 оны 12 сарын 8

Хүний эрхийн кино хэлэлцүүлэг

- I улиралд: “Девид Гейлийн Амьдрал”, Найруулагч: Элен Паркер, Гол дүрүүдэд: Кевин Спеси, Кейт Винслет, Лора Линнэй
- II улиралд: “Цуст алмаз”, Найруулагч: Элен Паркер, Гол дүрүүдэд: Кевин Спеси, Кейт Винслет, Лора Линнэй
- III улиралд: “48 цаг кино наадмын шилдэг бүтээлүүд”
- IV улиралд: “Pink”, Найруулагч: Анирудха Роё Чоудхури, Гол дүрүүдэд: Амиабх Баччан, Тапси Панну, Кирти Кулхари, Андреа Тарианг

Хүний эрхийн олон нийтийн лекц

- “Тогтвортой хөгжлийн 4-р зорилго: Нийгмийг хувирган өөрчлөх боловсролын хүч чадал” - Д.Тунгалаг, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч
- “Хүний эрхийг хангах парламентын чиг үүрэг” - Д.Цогтбаатар, УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга
- “Хүний эрхийг хамгаалахын тулд хүрээлэн буй орчныг хамгаалах нь” - Жон Нокс, НҮБ-ын Хүрээлэн буй орчин, хүний эрхийн тусгай илтгэгч
- “Ус ба хүний эрх” - Ц.Оюунгэрэл, Нутгийн шийдэл сангийн тэргүүн
- “Хүний эрх ба Эрүүгийн хууль” - Ж.Эрдэнэбулган, МУИС-ийн ХЗС-ийн захирал, Доктор, Профессор

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМЫГ БЭХЖҮҮЛЭХ



ХЭФ нь 2010 оноос эхлэн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг” механизмыг үр нөлөөтэй ашиглах чиглэлээр ажиллаж ирсэн билээ. Монгол Улс хоёр дахь хэлэлцүүлгээс хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан 150 зөвлөмжийн хэрэгжилтийн дунд хугацааны тайлан бэлтгэх 5 ажлын хэсгийг энэ онд байгуулж, холбогдох байгууллагад хандан мэдээлэл хүсэх, цуглуулах, цугларсан баримт мэдээлэлд тулгуурлан хэрэгжилтийн тайланг эхний байдлаар боловсрууллаа. ХЭФ-ын өмнөх онуудад явуулсан нөлөөллийн ажлын үр дүнд зөвлөмжийн хэрэгжилтийг хариуцан ажиллах Орон тооны бус зөвлөлийг төр, иргэний нийгмийн оролцоотой

байгуулж, жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор хариуцсан зөвлөмжийн хэрэгжилтийн талаар төрийн байгууллагууд зөвлөлд тайлагнах, зөвлөл хүлээж авсан тайланд үндэслэн хэрэгжилтийн асуудлыг хэлэлцэж, дараа жилийн 2 дугаар сарын дотор Засгийн газарт тайлагнах замаар хэрэгжилтэд хяналт тавих механизмыг бий болгосон нь том давуу тал юм. ХЭФ нь тус Орон тооны бус зөвлөлд гишүүн байгууллагуудаа томилж ажиллуулахын зэрэгцээ салбарын төрийн байгууллагын дэргэд Дэд зөвлөл байгуулахад нөлөөлж түүнд гишүүдээ нэр дэвшүүлэх чиглэлээр санаачилга гарган ажиллалаа. Энэ бүх хугацаанд ННФ нь ХЭФ, Хүний эрхийн Үндэсний комисс (ХЭҮК), Гадаад Харилцааны Яам, Хууль Зүй Дотоод Хэргийн Яам (ХЗДХЯ)-

тай дээрх асуудлаар хамтран ажиллах, харилцан санал солилцох зарчмыг баримтлан ажиллаж ирлээ. Мөн энэ чиглэлээр олон улсын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахыг чухалчилж ирсэн бөгөөд энэ хүрээнд UPR-Info байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулаад байна.

2015 оноос эхэлсэн сар тутмын хурал нь ХЭФ-ын үйл ажиллагааны үндсэн хэлбэр болж чадлаа. Гишүүн байгууллагууд сар тутмын хурлаа ээлжээр даргалж байгаа нь тэдний идэвхтэй, эрх тэгш оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн энэ онд гишүүн байгууллагууд Ёс зүйн дүрмээ баталж, түүнд нэгдсэн нь чухал үйл явдал боллоо. ХЭФ нь НҮБ-ын Хүний эрхийн хороонд

иргэний, улс төрийн эрхийн асуудлаар мэдээлэл хүргүүлж, гишүүн байгууллага тус Хорооны хуралдаанд оролцохын зэрэгцээ НҮБ-ын Хүрээлэн буй орчин, хүний эрхийн тусгай илтгэгчийн Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр идэвхтэй хамтран ажиллаж, энэ чиглэлээр тулгамдаж буй асуудлыг таниулахад анхаарч ажиллалаа. Үүний зэрэгцээ дотоодод болж буй хүний эрхийн асуудалд анхаарал хандуулж, хамтарсан нөлөөллийн ажил тогтмол хийж ирлээ. Тухайлбал, эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх зорилгоор “Таван хуулийн эвсэл” нэрийн доор 300 орчим төрийн бус

байгууллагатай эвлэлдэн нэгдэж, нөлөөллийн ажлыг амжилттай зохион байгууллаа.

ННФ нь ХЭФ-ыг бэхжүүлэх зорилгоор сургалт, хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалт, сар тутмын хурлаа зохион байгуулахад техникийн туслалцаа үзүүлээ. НҮБ-ын хүний эрхийн механизмаас хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх, энэ чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авах тухай зөвлөмжүүдийг удаа дараа өгч байсан бөгөөд ННФ нь ХЭҮК-той хамтран дээрх хуулийн төслийг боловсруулан УИХ-ын нэр бүхий гишүүдэд танилцуулаад байна.

Хүний эрхийн ТББ-уудын Форумын үйл ажиллагаа

- Форумын үйл ажиллагааны үндсэн механизм болох сар бүрийн хурал тогтмол (1, 2, 3, 4, 5, 6, 9, 10, 11, 12 сард) болов.
- НҮБ-ын Хүний эрхийн хороонд мэдээ бэлтгэн хүргүүлэх Ажлын хэсэг байгуулагдаж мэдээлэл хүргүүлэв. НҮБ-ын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгээс өгсөн зөвлөмжийн дунд хугацааны тайлан бэлтгэх Ажлын хэсгүүд байгуулагдан төрийн байгууллагад хандан мэдээлэл хүсэв. Түүнчлэн дээрх хэлэлцүүлгээс өгсөн зөвлөмжийн дунд хугацааны тайлан бэлтгэх Ажлын хэсгийн уулзалт хэлэлцүүлэг боллоо.
- II улиралд “Эрүү шүүлт ба Хүний эрх” сэдэвт сургалт, IV улиралд “Тогтвортой хөгжлийн зорилтууд” тайван цуглаан зохион байгуулав.



▲ Олон улсын хүний эрхийн өдрийг тэмдэглэх арга хэмжээг нээж Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож үг хэлж байгаа нь, 2017 оны 12 сарын 8.

- НҮБ-ын Хүний эрхийн хорооны хуралдаанд гишүүн байгууллагууд оролцсоны зэрэгцээ НҮБ-ын Хүрээлэн буй орчин, хүний эрхийн тусгай илтгэгчтэй амжилттай хамтран ажиллалаа.

“Хүний эрхийн хамгаалагчдын эрх зүйн орчныг бий болгох” хуулийн төслийг УИХ-ын нэр бүхий гишүүдэд танилцуулав.


“Хүний эрхийн тухай ярилцъя” өглөөний уулзалтууд

- “Хэвлэн нийтлэх эрх ба хүний эрх”, У.Тамир, ХМЗАА-ны дарга
- “Улаанбаатар хотын дахин төлөвлөлтөд хамрагдсан иргэдийн орон байртай байх эрх”, Монголын эмнести интернэшнл
- “Шинэчлэн найруулсан эрүүгийн хууль”, УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн
- “Зөрчлийн хуулийг эргүүлэн татсан үндэслэл”, Б.Одгэрэл, МУИС-ийн ХЗС-ийн багш, доктор
- “Монгол Улсын эрүүгийн процесс дахь халдашгүй, чөлөөтэй байх эрхийн баталгаа”, О.Мөнхсайхан, МУИС-ийн ХЗС-ийн багш, доктор
- “Ерөнхий боловсролын сургуулийн засаглалд эцэг, эх, багшийн оролцоо”, Д.Тунгалаг, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч
- “Хүрээлэн буй орчин ба хүний эрх”, Жон Нокс, НҮБ-ын Хүрээлэн буй орчин, хүний эрхийн тусгай илтгэгч
- “Хүний эрх, хууль, хөгжил”, П.Бадамрагчаа, ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер
- “Тогтвортой хөгжлийн зорилт, үзүүлэлтүүд”, М.Оюунжаргал, ҮСХ-ны Статистик, ЭШАЗГ-ын ахлах статистикч
- “Монгол Улс дахь хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал”, О.Нацагдорж, Хүний эрхийн хяналтын төв ТББ-ын Тэргүүн

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, МЭДЛЭГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ

ННФ-аас зохион байгуулдаг хүний эрхийн боловсрол, мэдлэг түгээн дэлгэрүүлэх болон нийгэмд өрнөж буй хүний эрхийн “халуун” сэдвээр өрнүүлдэг хэлэлцүүлэг тогтмолжиж, агуулга болон хамрах хүрээ нь өргөжиж байна. Тухайлбал, ХЭҮК-той хамтран зохион байгуулдаг “Хүний эрхийн олон нийтийн лекц”, “Хүний эрхийн тухай ярилцъя” арга хэмжээний хүрээнд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, иргэдийн оролцоо, хүрээлэн буй орчны эрх, тогтвортой хөгжил, эрх зүйн шинэчлэлийн эргэн тойронд өргөнөөр яриа өрнүүлээ. Үүний зэрэгцээ 2015 оноос эхлүүлсэн “Хүний эрхийн кино хэлэлцүүлэг” нь

хүрээгээ тэлж нийслэл төдийгүй хөдөө орон нутагт зохион байгуулагдах болсон бөгөөд хүний эрхийн мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлэх чухал арга хэрэгсэл болохыг хэлэлцүүлэгт оролцогчид үнэлж байна. Түүнчлэн эдгээр үйл ажиллагаа нь хүний эрхийн чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдийг бий болгох, энэ чиглэлийн судалгаа, шинжилгээг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Хүний эрхийн асуудлыг хойш тавих, хөгжлийн саад тоггор хэмээн үзэх хандлага цухалзах болсон энэ үед дээрх чиглэлийн үйл ажиллагааг тогтмол давтамжтайгаар зохион байгуулах хэрэгцээ, шаардлага байсаар байна.



▲ Орон нутгийн төрийн бус байгууллагуудын төлөөлөл Улаанбаатар хот дахь иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үеэр Өвөрхангай аймгийн Орон нутгийн сургалт судалгааны агентлаг ТББ-ын ажилтан А.Оюунчимэг Эмнести Интернэшнл байгууллагатай танилцав. 2017 оны 12 сар

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ



▲ 2017 он 8 сарын 24-25-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан “Цагдаагийн албаны үйл ажиллагаанд мониторинг хийх төрийн бус байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх” сургалтын үеэрх бүлгийн ажиллагаа

Энэ сэдвийн хүрээнд ННФ нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах шатанд иргэний нийгмийн бодит оролцоог нэмэгдүүлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад техникийн туслалцаа үзүүлэх, Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг

нэмэгдүүлэх, бие даасан судалгаа, мониторингийн үр дүнг бодлого боловсруулагчдад хүргэх чиглэлээр анхаарч ирлээ. Өнгөрсөн онд эрүүгийн багц хууль, хөдөлмөрийн тухай хуулиудад санал шүүмж өгөхийн зэрэгцээ, шинэ хуулиудын хэрэгжилтэд хөндлөнгийн мониторинг хийж үр дүнг танилцууллаа.

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ҮЙЛ ЯВЦАД ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГАД ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ НЬ

Эрх зүйн шинэ орчныг иргэний нийгэмд таниулах, энэхүү шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд иргэний нийгмийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор

2014 оноос эхлүүлсэн “Хуулийн хэлэлцүүлэг” энэ онд ч мөн үргэлжиллээ. Хөдөлмөрийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудын

ХУУЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

- “Эрүүгийн хууль”-ийн нэмэлт, өөрчлөлтөд санал өгөх уулзалт зохион байгуулав.
- “Таван хуулийн эвсэл” ажлын хэсэг эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн асуудлаар ажиллалаа.
- “Иргэний зөвлөлийн дүрэм”-д санал өгөх хэлэлцүүлэг зохион байгууллаа.
- “5 хуулийн эвсэл” ажлын хэсэг эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн асуудлаар ажиллалаа.
- ХЭФ-аас УИХ-ын даргад хандан Эрүүгийн багц хуулийн хэрэгжилтийн бэлтгэл хангах асуудлаар албан бичиг хүргүүлээ.
- “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад санал өгөх хэлэлцүүлэг зохион байгууллаа.
- “Захиргааны ерөнхий хууль” хэрэгжиж эхэлсний нэг жилийн ойг тохиолдуулан хэлэлцүүлэг зохион байгууллаа.

СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- “УБ Форум” хэлэлцүүлэг зохион байгууллаа.
- “Орон нутагт хүний эрхийн хамгаалал, нөлөөлөл хийх чадавхыг бэхжүүлэх нь” хоёр дахь шатны сургалтыг I улиралд Дундговь, Өмнөговь аймгийн 29 төрийн бус байгууллагаыг оролцуулан Өмнөговь аймагт, II улиралд 8 аймгийн 64 төрийн бус байгууллагыг оролцуулан Баянхонгор, Хэнтий аймагт тус тус бүсчлэн зохион байгуулав.
- “Цагдаагийн албаны үйл ажиллагаанд мониторинг хийх төрийн бус байгууллагын чадавхыг бэхжүүлэх” сургалтыг ННФ-аас мониторингийн тэтгэлэг авсан 9 төрийн бус байгууллага болон ННФ-ын 2 шатны сургалтад хамрагдсан 21 аймгийн төрийн бус байгууллагыг оролцуулан зохион байгуулав.
- Орон нутгийн мониторингийн багийн үйл ажиллагаатай танилцах аяллыг Дархан-Уул, Орхон аймагт зохион байгууллаа.
- Цагдаагийн албаны үйл ажиллагаанд хийх бичил мониторингийг амжилттай хэрэгжүүлсэн 3 аймгийн багуудыг оролцуулсан танилцах аяллыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, үр дүнг нь баримтжуулсан видео бэлтгэн түгээв.



▲ Хэнтий аймгийн Чингис хотод зохион байгуулсан Орон нутгийн ТББ-ыг чадавхжуулах II шатны сургалт, хууль сахиулах ажиллагаатай танилцах дадлагын үеэр. 2017 оны 4 сарын 13

төсөлд тус тус санал шүүмж өгсний зэрэгцээ, эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд гарсан ололт амжилтыг бататгах, алдаа дутагдлыг засах зорилго бүхий “Таван хуулийн эвсэл” иргэний нийгмийн сүлжээнд нэгдэн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгууллаа.

Хуулийн төсөл боловсруулахад иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ шинээр баталсан хуулийг тэдэнд танилцуулах, энэ чиглэлээр мониторинг хийх чадавх бий болгоход анхаарч ажиллаж байна. Эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэхэд хариуцлагатай, чадварлаг иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг их билээ. Гэтэл иргэний нийгэм, тэр дундаа хөдөө орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын чадавх сул, ялангуяа хуулийн болон хууль сахиулах салбарын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт, мониторинг хийх чадавхгүй, энэ чиглэлээр ажилладаг байгууллага ч

цөөн байна. Тиймээс ННФ 2015 оноос эхлэн орон нутгийн иргэний нийгмийн байгууллагынханд зориулан хоёр үе шаттай сургалтыг бүсчлэн зохион байгуулж ирсэн билээ. Өнгөрсөн онд хоёр дахь шатны сургалтыг Хэнтий, Баянхонгор, Өмнөговь аймгуудад бүсчлэн зохион байгуулж 11 аймгийн 93 төрийн бус байгууллагын ажилтнууд оролцлоо. Ингэснээр нийт 21 аймгийн 300 орчим байгууллага 3 жилийн хугацаанд хоёр шатны сургалтад хамрагдлаа. Сургалтаар хязгаарлагдахгүй оролцсон төрийн бус байгууллагуудад бэсрэг мониторингийн тэтгэлэг олгож, арга зүйгээр хангаж ажилласнаар танхимд олж авсан мэдлэгээ практикт ашиглах боломж олгов. Үүний дүнд уламжлалаараа хаалттай байсан салбарт иргэний нийгмийн оролцоог бий болгох чухал эхлэлийг тавьж чадлаа. Сургалт явуулсан 3 жилийн хугацаанд нийтдээ орон нутгийн 100 орчим төрийн бус байгууллага хууль сахиулах салбарын зарим

үйл ажиллагаанд мониторинг хийгээд байна. 2017 онд 21 аймгийн 67 төрийн бус байгууллага “Цагдаагийн албаны үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамж, иргэний зөвлөл, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаа” сэдвийн хүрээнд бэсрэг мониторинг хийлээ. Тус мониторингийн хүрээнд ННФ нь ЦЕГ-тай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан

хамтран ажилласан юм. Эрх зүйн шинэчлэлд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ хууль сахиулах байгууллагад хүний эрхийг хангаж ажиллах чадавхаа нэмэгдүүлэхэд нь техникийн туслалцаа үзүүлэв. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хуяглан хүргэх эрэн сурвалжлах

тасагтай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд алба хаагчдад зориулсан гарын авлага, сургалтын хөтөлбөр боловсруулахад нь туслалцаа үзүүлэв. Мөн шинээр баталсан Цагдаагийн албаны тухай хуульд нийцүүлэн боловсруулсан Иргэний зөвлөлийн дүрэмд санал өгсөн нь тусгалаа оллоо.

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН МЭДЛЭГ, МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ

Бид 2014 онд “Театр хүний эрхийн төлөө” төслийн хүрээнд Глоб интернэшнл ТББ болон УДЭТ-тай хамтран “тавилттай уншлага” хэмээх үзвэрийн шинэ төрлийг мэргэжлийн театр, мэргэжилтнүүд болон зохиолчдод танилцуулж эхэлсэн билээ. Улмаар нийгмийн тулгамдсан асуудлыг театраар дамжуулан бодлого

боловсруулагч, олон нийтэд таниулахыг зорьж УДЭТ-аас гадна орон нутгийн хэд хэдэн театрт хүний эрхийн зөрчил, нийгмийн шударга бус байдал зэрэг сэдвээр “тавилттай уншлага” болсон билээ.

Харин өнгөрсөн онд шинээр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай

хуулийн хүрээнд хүний эрхийг баталгаажуулсан шинэлэг зохицуулалтыг олон нийтэд хүргэх зорилгоор “Хуулийн өмнө”, “Наран цамхгийн хэрэг”, “Манаач” сэдэвт гурван бэсрэг жүжгийн зохиол бичихэд дэмжлэг үзүүлээ. Тус бэсрэг жүжгийн тавилттай уншлагыг хийж, бичлэгийг цахимаар олон нийтэд хүргэхээр зорьж байна.

МОНИТОРИНГ

ННФ-ын хувьд төрийн үйлчилгээнд мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжиж, ажилладаг чиглэлээр нь чадавхжуулж ирсэн нь төрийн бус байгууллагыг үйл ажиллагааны хувьд бэхжүүлэх чухал хөтөлбөр болдог. Иймээс бид иргэний нийгмийн байгууллагууд төрийн үйлчилгээнд ажиглалт хийх Мониторингийн хөтөлбөрийг 10 гаруй жил хэрэгжүүлж байна.

Энэ хөтөлбөрийн хүрээнд 2014 оноос эхлэн хууль сахиулах салбарт мониторинг хийх төрийн бус байгууллагыг чадавхжуулах, мониторингийн тэтгэлэг олгох зэргээр ажиллаж ирсэн бөгөөд үүний дүнд энэ салбарт мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагын тоо жилээс жилд нэмэгдэж байна.

Энэ онд цагдаагийн албаны үйл ажиллагааны ил тод байдал, цагдаагийн байгууллага олон

нийтэд ажлаа тайлагнах үйл явц, ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн талаар гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх цагдаагийн албаны чиг үүргийн хэрэгжилт зэрэг сэдвээр 7 мониторингийн төсөл хэрэгжүүллээ. Мониторингийн дэлгэрэнгүй үр дүнг www.forum.mn цахим хуудсаас үзнэ үү.

ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

“Шүүхийн хараат бус байдал ба олон нийтийн хяналт” хэлэлцүүлгийн үеэр тавигдсан илтгэлүүд

“Шүүгчийн хараат бус байдал, шүүгчийн нэр хүнд, халдашгүй байдал” - Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн, шүүгч М.Батсуурь

“Олон нийтийн хяналт ба шүүмж, шүүгч шударга шүүмжлэлээс ангид байх уу?” - МУИС-ийн ХЗС-ийн багш, доктор О.Мөнхсайхан

“Шүүгчид нөлөөлөх хэлбэр, нөлөөллийн мэдүүлэг” - Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах хэлтсийн дарга Б.Одонгэрэл

“Шүүгч нийгэм дэх дуулиан, мэдээллээс хараат бус байх нь” - Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач Л.Галбаатар, С.Батболд

“Хэвлэн нийтлэх эрх ба шүүгчийн хараат бус байдал” - МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор Б.Болд-Эрдэнэ

“Шүүхийн хөндлөнгийн мониторинг” - Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа



▲ “Шүүхийн хараат бус байдал ба олон нийтийн хяналт” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр ННФ-ын Засаглалын менежер П.Бадамрагчаа “Шүүхийн хөндлөнгийн мониторинг” сэдвээр илтгэл тавив. 2017 оны 11 дүгээр сарын 30

Нээлттэй Нийгэм Форум 2017-2019 оны стратегийнхаа хүрээнд шүүхийн шинэтгэлийн процессыг зохистойгоор шаардах хөндлөнгийн бие даасан институцуудын оролцоо, дуу хоолойг бий болгохыг зорьж ажиллаж байгаа билээ. Энэ хугацаанд нэг талаас, эрдэмтэн судлаачид, бие даасан шинжээчид, иргэний нийгмийн байгууллагынханд хөндлөнгийн дүн шинжилгээ, ажиглалт,

мониторинг хийх боломж олгох, чадавхыг нэмэгдүүлэх; нөгөө талаас тэдний боловсруулан гаргасан мэдээлэл, баримт материалыг шинэтгэлийн үйл явцад ашиглах зорилт дэвшүүлэн тодорхой ажлууд хийгдэж эхлээд байна. Энэ нь хууль, эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, гарч буй зөрчил дутагдлыг цаг тухайд нь засаж залруулахад тус нэмэр оруулна гэж үзэж буй.

ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Манай улсад шүүхийн шийдвэрийг олон нийтэд нээлттэй болгосон нь (shuukh.mn) мэдээллийн ил тод байдлын зохих стандартыг хангаж буй сайн туршлага юм. Харин ил болсон шийдвэрүүдийн үндэслэлд дүн шинжилгээ тогтмол хийж байх нь шүүхийн шийдвэрийн чанарыг дээшлүүлэхээс гадна шүүгчийн ажлын гол шалгуур болно. Бид 2016 оноос МУИС-ийн Хууль зүйн сургуультай хамтран шүүхийн шийдвэрийн үндэслэлд дүн шинжилгээ хийж эхэлсэн юм. Энэ нь хууль хэрэглэх ажиллагааны академик болон практик үр нөлөөг дээшлүүлэх, хуулийн сургуулийн оюутнуудад сургалтын хэрэглэгдэхүүн болох, шүүхийн шийдвэрт хөндлөнгийн байр сууриас мэргэжлийн үнэлгээ өгөх, улмаар шүүгчдийн хууль хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэх, шүүх дэх олон нийтийн хяналтыг дээшлүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

ННФ 2017 онд Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах, Гэр бүлийн маргаан, Шүүхээр гэм буруугүйг тогтоож, цагаатгасан хэргийн улмаас цагдан хорих арга хэмжээ авагдсан этгээдийн хохирлыг барагдуулсан байдал зэрэг тодорхой хэрэг маргааны шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх төслүүдийг сонгон дэмжсэн нь шүүгч, хуульчдын мэргэжлийн

үйл ажиллагаа болон хуулийн хэрэглээнд хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт болж чадлаа. 2018 онд эдгээр дүн шинжилгээг салбарын хүрээнд хэлэлцүүлэх цаашид шүүгч, хуульчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлд нөлөөллийн ажил хийхээр зорьж байна. Дээрх тодорхой төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд “Хөгжлийн академи”, “Оюуны инноваци”, “Эрх зүйн соёл болон Эрх зүйн хөгжлийн төлөө” төрийн бус байгууллагуудын судлаачид дүн шинжилгээ хийлээ (Тайлангийн Төрийн бус байгууллагуудын хийсэн судалгааны товч дүн хэсгийг үзнэ үү).

Шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангаж ажиллах үндсэн чиг үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ)-өөс шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах бие даасан хэлтэс байгуулсан нь энэ чиглэлийн үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, шүүгчдэд үзүүлэх гаднын нөлөөг арилгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг онцгой ач холбогдолтой юм. Дээрх хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, хамтран ажиллах талуудтай ойлголцолд хүрэх зорилгоор 2017 оны 11 дүгээр сарын 30-нд ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Шүүхийн хараат бус байдал ба олон нийтийн хяналт” сэдэвт

“Шүүхийн ажиглалт 2017” төсөлд хамтран ажилласан иргэний нийгмийн байгууллагууд:

Булган

- Гэрэлт ирээдүйн оршихуй ТББ
- Булганы мэдээ сонин
- Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сан

Дархан-Уул

- Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн салбар
- Мэдээллийн Орхон XXI зуун төв
- Аз жаргалын эрэлд ТББ

Дорнод

- Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн – салбар
- Улс төрийн боловсролын академи

Завхан

- Эмнести интернэшнл Завхан бүлэг
- Ахмад мэргэжилтний холбоо
- Залуусын өөртөө туслах байгууллага

Орхон

- Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн салбар
- Эрдэнэт хүмүүний Эв нэгдэл ТББ
- Төр-Иргэн Түншлэл ТББ
- Ариун хэлхээ ТББ

Өвөрхангай

- “Эх нутаг хөгжил” төв ТББ
- Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны сан ТББ – салбар
- Хүчирхэг үндэстэн ТББ
- Өвөрхангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо

Өмнөговь

- Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн
- Говийн хөгжлийн зуун ТББ
- Ахмадын хороо

Увс

- Өсвөр үе ирээдүй Увс төв
- Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн холбоо – салбар
- Скаутын холбоо – салбар

Хэнтий

- Ажил олгогч эздийн холбоо салбар
- Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ
- Хэнтий мэдээ сонин
- Хэрлэн тоонот эко ТББ

Хөвсгөл

- Сүүн тахилт ТББ
- Мөрөн сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо
- Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо

хэлэлцүүлэг зохион байгууллаа. Энэхүү хэлэлцүүлэг нь шүүгчийн хараат бус байдал ба хэвлэл мэдээлэл, олон нийтийн зүгээс тавих хяналтын тэнцвэрийг хангахад тулгамдаж буй асуудал, талуудын байр суурийг таньж мэдэх, цаашид зохистой ажиллах

эрх зүйн орчныг тодорхойлоход ач холбогдолтой байсан юм. Уг хэлэлцүүлэгт шүүгч, судлаач, сэтгүүлч, иргэний нийгмийн төлөөлөгчид судалгаа, мэдээллээ танилцуулж, илтгэл тавьж оролцогчид санал бодлоо солилцлоо.

ШҮҮХИЙН АЖИГЛАЛТ, МОНИТОРИНГ

2015-2016 онд бүсчлэн зохион байгуулагдсан шүүхийн ажиглалтын арга зүйн сургалтад нийт 20 аймгийн иргэний нийгмийн төлөөлөл хамрагдаж тэдгээрээс 13 аймагт нь дадлага төсөл хэрэгжүүлсэн юм. 2017 онд сургалтад оролцсон төрийн бус байгууллагуудаас сонирхлоо илэрхийлсэн 10 аймгийн ажиглалтын багтай хамтран “Шүүхийн ажиглалт 2017” төсөл хэрэгжүүлээ. Төслийн багууд 2017 оны 5 дугаар сарын 8-аас 6 сарын 30-ны хооронд нийт 8 долоо хоногийн хугацаанд эрүүгийн анхан шатны 330 шүүх хуралдаанд ажиглалт хийсэн юм.

Шүүхийн ажиглалтын дүн мэдээг нэгтгэн шинжлэхэд эрх зүйн судалгааны “Оюуны Инноваци” ТББ-тай хамтран ажилласан болно.

Ажиглалтын дүнгээс харахад шүүхийн ажиллагаа харьцангуй нээлттэй болж, захиргааны ажилтны ур чадвар дээшилсэн нь сайшаалтай ч шүүх хуралдаан хойшлох явдал нэмэгдсэн нь анхаарал татаж байлаа. Түүнчлэн Тахарын алба татан буугдсантай холбоотой дэг сахиулах хуяг шүүх хуралдааны туршид бүрэн байлцахгүй тохиолдол гарч байгаа нь ажиглалтаар харагдлаа.



▲ Шүүхийн ажиглалтын сургалтын үеэр оролцогчид дүрд тоглох аргаар ажиглалт хийх дадлага эзэмшиж буй нь, 2017 оны 4 дүгээр сарын 27




**ХӨГЖЛИЙН
АКАДЕМИ ТББ**

**Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн
шүүхийн шийдвэрлэлт**

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгааг статистик мэдээлэл харуулж байна.

**Хүүхдийн тусламжийн утас 108-д
ирсэн дуудлага**



Эх сурвалж: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэдээлэл

2015 оны Эрүүгийн шинэ хуульд хүүхдийн эсрэг үйлдсэн хүчингийн гэмт хэрэгт оногдуулах ял болон бусад зарчимд томоохон өөрчлөлт оруулсан. Тухайлбал, хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд нь хүйс ялгаварлалгүй байх, 14-өөс доош насны хүүхдийн эсрэг үйлдсэн хүчингийн хэргийг хуульд заасан арга шаардахгүй буюу бэлгийн харьцаанд орсон л бол хүчиндэх гэмт хэрэгт тооцохоор заасан. Түүнчлэн ураг зулбасан, гэр бүлийн хамаарал бүхий хүнийг хүчиндэх, гэр бүлийн

хамаарал бүхий 16 насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх болон жирэмсэн болгох зэрэг үйлдэл тус бүрийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд тооцсон. Мөн бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцож, хуульд тайлбар оруулсан нь сайшаалтай. Гэсэн хэдий ч ялын хугацааг багасгасан нь тус гэмт хэргийн хор уршигтай харьцуулахад нийцсэн заалт болж чадаагүй харин ч хөнгөрүүлсэн байна гэж үзэж байна.



**ЭРХ ЗҮЙН СОЁЛ
ТББ**

**Шүүхээр гэм буруугүйг тогтоож, цагаатгасан хэргийн улмаас
цагдан хорих арга хэмжээ авагдсан этгээдийн хохирлыг
барагдуулсан байдал**

Цагдан хорих нь өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг авах боломжгүй тохиолдолд л хэрэглэдэг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны албадлагын эцсийн арга хэмжээ юм. Энэ арга хэмжээ нь хүний хувийн эрх, эрх чөлөөг хязгаарлаад зогсохгүй, сэтгэл санаа болон бие махбодийн эрүүл мэнд, нэр төр, ажил амьдрал, гэр бүлийн байдалд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэлтэй албадлагын арга хэмжээ байдаг. Иймээс үндэсний болон олон улсын түвшинд энэ талаар эрх зүйн нарийн зохицуулалт, хамгаалалт

тогтоож өгсөн байдаг. 2013-2017 онд мөрдөн байцаагч, прокурорын буруутай үйл ажиллагааны улмаас цагдан хоригдсон боловч шүүхийн шийдвэрээр цагаатгагдсан иргэдийн талаарх мэдээллийг шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийхэд хувийн баталгаа гаргах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, барьцаа авах, цагдан хорих, оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах, батлан даалтад өгөх, эд хөрөнгө

барьцаалах зэрэг таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан нийт 173 шийдвэр байна. Түүний 45 буюу нийт цагаатгасан хэргийн 26 хувьд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан байна. Шүүхийн практикаас харахад хилсээр арга хэмжээ авагдсан иргэд учирсан хохирлоо бүрэн барагдуулах, нөхөн төлүүлэх эрх зүйн боломжгүй байгаа бөгөөд ялангуяа эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудлыг онцгойлон авч үзэх шаардлагатай байна.



Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалсан хэрэг маргааны шүүхийн шийдвэрлэлт


2016 оны 2 дугаар сард батлагдсан Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ЗХШХШТХ)-ийн §18.3-т зааснаар хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд нь тухайн хуульд заасан асуудлаар, харин бусад этгээд “нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх”, “дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх” гэсэн хоёр шаардлагыг хангасан нөхцөлд хүрээлэн байгаа орчин (1), хүүхдийн эрх (2), нийтийн эрүүл мэнд (3), нийтийн өмч (4) гэсэн дөрвөн асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй болсон.

Ийнхүү илүү мэдээлэлтэй, туршлагатай, асуудалд илүү ойр байж ул суурьтайгаар харж чадах хэсэг буюу төрийн бус,

мэргэжлийн байгууллагад нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар захиргааны хэргийн шүүхэд хэрэг хэлэлцүүлэх эрх, боломжийг нээснээрээ нийтийн ашиг сонирхол хангагдах баталгааг илүү нэмэгдүүлсэн.

ЗХШХШТХ 2016 оны 7 дугаар сарын 1-ээс эхлэн даруй хоёр жил шахам хэрэгжиж байгаа бөгөөд энэ хугацаанд төрийн бус байгууллагууд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн 17 нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүхэд гаргасан байна. Үүнээс 5 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, нэгийг бүрдүүлбэр хангуулж ирүүлээгүй үндэслэлээр буцааж, 11 нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэсэн байна. Захиргааны хэрэг үүсгэсэн 11 хэргийн 4 нь хянан шийдвэрлэх ажиллагаанд, 7 нь шийдвэрлэгдсэн байна.

Төрийн бус байгууллагуудаас нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан салбар



- Байгаль орчин
- Хүүхдийн эрх
- Нийтийн эрүүл мэнд
- Нийтийн өмч
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх



ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ТББ

Гэр бүлийн хэрэг маргааны шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдал

2017 оны байдлаар хянан шийдвэрлэсэн хэрэг маргаанаас гэр бүлийн маргаан өмнөх оноос 108 – аар буюу 2.3 хувиар өсжээ. Ерөнхий байдлаар шүүхээр шийдвэрлэгдсэн гэр бүлийн маргааны тоо 4566 буюу иргэний нийт хэргийн 10.1 хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан шүүхийн нийт 80 шийдвэр, магадлал, тогтоолын 90 хувьд нь хүүхдийн

асрамжийн асуудлыг шийдвэрлэжээ. Эдгээр шийдвэрийн үндэслэл болон тогтоох хэсгийг шинжлэн судлахад шүүх хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ зохих хууль тогтоомжийг хэрэглэхгүй байх, эсхүл буруу тайлбарлаж хэрэглэх, хүүхдийн эрх ашгаас илүү эцэг, эх, эмэг эх, өвөг эцгийн саналыг харгалзах, зохигчдын тайлбар, шинжээчийн дүгнэлтийг

хэрэгт авагдсан бусад баримттай харьцуулан дүгнэхгүйгээр асрамжийг тогтоох зэрэг нийтлэг алдаа гаргасан байв. Үүнээс гадна асрамжийг шийдвэрлэхдээ хүүхдийн саналыг авдаггүй, авсан ч харгалзаж үзэхгүйгээр шийдвэрлэдэг хандлага цөөнгүй ажиглагдлаа.

2017 онд иргэний нийгмийн байгууллагуудын дунд шүүхийн мониторингийн нээлттэй төслийн уралдаан зарлаж 6 төсөл шалгаруулан дэмжсэн юм. Нийт ирсэн төслийн 60 хувь, дэмжигдсэн 6 төслийн 5 нь орон нутгаас иржээ. Энэ нь 2015 оноос эхлэн орон нутгийн төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах чиглэлд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн гэж дүгнэж байна.

Дархан-Уул, Дорнод, Хөвсгөл аймгуудад хийгдсэн “Шүүхийн хараат бус, аюулгүй байдлыг хангасан байдалд хийсэн

мониторинг” - ийн дүнгээс харахад орон нутагт шүүхийн хараат бус байдал харьцангуй сайн хангагдсан гэж үзэхээр байна. Харин шүүхийн аюулгүй байдлын тухайд Цагдаагийн байгууллага хариуцдаг болсон нь учир дутагдалтай байгааг хэд хэдэн үндэслэлээр тайлбарлажээ. Үүнд:

- Шүүхэд ажиллах цагдаагийн албан хаагчдын тоо хангалтгүй. Зарим тохиолдолд шүүх хуралдаан дэг сахиулах цагдаагүйгээр явагдаж байна.
- Цагдаагийн байгууллагын

хүлээх үүрэг нь одоо мөрдөж байгаа журамдаа ойлгомжгүй, тодорхой биш тусгагдсан.

- Шүүхэд ажиллахтай холбоотой зардал нь цагдаагийн байгууллагын төсөвт тусгайлан тусгагдаагүйгээс нөөц хүрэлцдэггүй. Шүүхийг хамгаалж байгаа цагдаа нарт илүү цагийн хөлс олгодоггүй, харуулаас буухад нь бүрэн амраадаггүй дахин хэв журмын эргүүлд улируулан гаргах зэрэг нөхцөл байдал үүсдэг байна.

ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ АЖИЛТНУУДЫН СУРГАЛТ

Форум нь шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлд хөндлөнгийн байр сууринаас судалгаа шинжилгээ хийх, хэлэлцүүлэг өрнүүлэхийн зэрэгцээ шаардлагатай тохиолдолд шүүхийн захиргааны ажилтнуудын хандлага, ур чадварыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлж ирлээ.

2016 оноос ШЕЗ-өөс сургалтын зохион байгуулалтад өндөр

ач холбогдол өгч хамтран ажилласан бөгөөд шинээр байгуулагдсан Шүүхийн сургалтын төвд ШЕЗ-ийн Хүний нөөцийн хэлтэс, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнтэй хамтран 2017 онд 2 удаа сургалт зохион байгууллаа. Шүүхийн зохион байгуулалт хариуцсан ажилтнуудад зориулсан сургалтыг 2017 онд гурав дахь удаагаа амжилттай зохион байгуулсан ба цаашид энэхүү сургалтыг ШЕЗ бие

даан зохион байгуулахаар болсон нь сайшаалтай. Өмнөх туршлагадаа тулгуурлан 2017 оноос эхлэн шүүхийн мэдээлэл лавлагааны ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх зорилго бүхий сургалт, семинар зохион байгуулаад байна. Уг сургалт нь тэдний өдөр тутмын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхээс гадна мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд тус дэм болно гэж үзэж буй.

ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Эрх зүйн цахим хөтөч

Эрх зүйн албан ёсны мэдээллийг нэг дороос, цагийн хязгаарлалтгүй, энгийн ойлгомжтой хэлбэрээр олж авах боломжийг эрх зүйн цахим хөтөч (www.e-khutuch.mn) олгоно. Энэхүү цахим хуудсаар хамгийн эрэлттэй байгаа эрх зүйн мэдээлэл, зөвлөгөөг бэлтгэн иргэдэд хүргэхийг зорьж буй. Тэрчлэн эрх зүйн хөтөч сайтад эрх зүйн сургалт явуулахад шаардлагатай гарын авлага, танилцуулга, видео контентийг байрлуулна. Төрийн бүх шатны байгууллага, салбарын яам агентлаг, эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, нөөцийг зохистойгоор уялдуулж ажилласнаар энэхүү эрх зүйн цахим хөтчийн хүртээмж сайжирч, үр нөлөө нь дээшлэх болно.



▲ www.e-khutuch.mn сайтын нүүр хуудас

Монгол Улсын Үндэсний статистикийн газрын 2017 оны мэдээллээр 900 мянга гаруй хүн суманд, 650 мянга гаруй хүн аймгийн төвд, 1,4 сая гаруй хүн нийслэл хотод амьдарч байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад эрх зүйн шинэтгэл эрчимжиж, иргэдийн амьдралд эергээр нөлөөлөх олон шийдвэр гарч байгаа хэдий ч бодит амьдралд хуулийн хамгаалалт, төрийн үйлчилгээнд хамрагдахад бэрхшээл учирсан хэвээр байна. Ялангуяа хөдөө орон нутагт хууль эрх зүйн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа нь

судалгаагаар харагддаг. Улсын хэмжээнд 5300 гаруй бүртгэлтэй хуульчид үйл ажиллагаа явуулж байгаа ч тэдний 70 гаруй хувь нь зөвхөн нийслэл хотод ажиллаж байна (<https://mgjbar.mn>).

Төрөөс нэгэнт гаргасан шийдвэр, мэдээллийг иргэд амьжиргаагаар дээшлүүлэхэд ашиглахад нь туслах, аливаа бэрхшээл учирсан тохиолдолд зөрчигдсөн эрхээ нэхэмжлэх чадвар, боломжоор хангах нөхцөлийг бодитоор бүрдүүлэх шаардлагатай. Мөн төрийн байгууллагаас гаргах аливаа шийдвэр, бодлого боловсруулах

үйл явц нь иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх, зөрчих тохиолдолд тэдний үзэл бодол, байр суурийг сонсох боломжоор

хангах ёстой билээ.

ННФ 2016 оноос эхлэн иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх

хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд 2017 онд дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүллээ.

БОДЛОГЫН НӨЛӨӨЛӨЛ



▲ Өмнөд Африкийн Йоханнесбург хотод эрх зүйн хөтчийн үйл ажиллагаатай Монголын төлөөлөгчид танилцлаа. 2017 оны 11 сарын 2

2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд бүрдсэн шинэ Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрх зүйн чадавхыг дээшлүүлэх үзэл баримтлалыг тусгаж, хэрэгжүүлэх чиглэлд бодлогын нөлөөлөл хийн зөвлөхийн тусламжтайгаар Хууль зүй дотоод хэргийн яам (ХЗДХЯ)-тай хамтын ажиллагаагаа бэхжүүллээ.

Нээлттэй Нийгэм Форум 2016 онд ХЗДХЯ-тай хамтран ажиллах үйл ажиллагаагаа тодорхойлж, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан юм. Санамж бичгийн хүрээнд “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг

дээшлүүлэх” үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажлыг дэмжин ажиллахаар зааж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн төлөөллийг гадаад улс орны туршлагатай танилцуулах ажлыг төлөвлөсөн болно. Энэ хүрээнд 2017 оны 10 дугаар сарын 30-аас 11 дүгээр сарын 5-ны хооронд Өмнөд Африкийн Йоханнесбург хотод олон улсын дугуй ширээний ярилцлага, туршлага солилцох аялал зохион байгуулагдлаа. Энэхүү аялалд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн гишүүд болох ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Г.Цэцгээ, Хууль

зүйн туслалцааны төвийн Захиргаа удирдлагын газрын дарга Ж.Бариширсүрэн, Глоб Интернэшнл төвийн төслийн зохицуулагч Б.Сарантуяа нар оролцов. Түүнчлэн Нээлттэй Нийгэм Сангуудын Эрх зүйн санаачилга хөтөлбөрөөс зохион байгуулдаг “Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь – Манлайлал” сэдэвт ээлжит сургалтад Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний хөтөлбөр боловсруулах болон хэрэгжүүлэх шатанд хамтран ажиллах талууд болох Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал С.Энхцэцэг, Хууль зүйн туслалцааны төвийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Ж.Бариширсүрэн нарыг дэмжиж оролцууллаа. Уг сургалт нь Төв Европын их сургуультай хамтран зохион байгуулагдсан юм.

Хөтөлбөр боловсруулах, хэлэлцүүлэх ажлыг баримтжуулах, олон нийтэд мэдээлэх үүднээс 2016 онд зохион байгуулсан “Иргэдийн эрх зүйн чадавхын өнөөгийн байдал” бүсийн хэлэлцүүлгийн видео нэвтрүүлэг болон төслийн талаар видео танилцуулга, реклам бэлтгэж олны хүртээл болгоод байна.

ЭРХ ЗҮЙН ЦАХИМ ХӨТӨЧ

Бүх нийтийн эрх зүйн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх нэг гол ажил нь эрх зүйн мэдлэг, мэдээллийг нэг дороос цахим хувилбараар, нээлттэй хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх үндсэн зорилго бүхий www.e-khutuch.mn цахим хөтөч бий болгож ажиллагаанд оруулах явдал юм. Энэхүү цахим хөтчийг агуулга болон технологийн хувьд хөгжүүлэх үндсэн үүргийг Хууль зүйн үндэсний хүрээлэн хүлээж байгаа ба ННФ-ын санхүүжилтээр албан

ёсны контент боловсруулах ажлаа эхлүүлээд байна. Уг агуулга нь судалгаанд үндэслэн хамгийн нийтлэг хэрэгцээтэй байгаа сэдвийн хүрээнд боловсруулагдаж байгаа бөгөөд хялбар ойлгогдохуйц, ашиглахад хялбар, шинэлэг байх шаардлагуудыг хангаж байгаа болно.

Эрх зүйн цахим хөтөч нь бүх насны иргэдэд зориулагдсан бөгөөд төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл болон, эрх зүйн тулгамдаж буй бүхий л асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэхэд

туслах анхан шатны эрх зүйн зөвлөгөөг цахим хэлбэрээр өгөх ба холбон зуучлах нэг цэг, нэгдсэн мэдээллийн сан байх болно. Түүнчлэн, энэхүү цахим хөтчийг ашиглан Монгол орны өнцөг булан бүрээс оршин суугаа газрынхаа (аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо) эрх зүйн болон бусад холбогдолтой мэдээ, мэдээллийг авах боломж иргэдэд нээгдэх юм. Цахим хөтөч буюу www.e-khutuch.mn сайтыг боловсруулах програмын ажлыг ННФ-аас санхүүжүүлэн хэрэгжүүлж байна.

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА

Үндсэн хуульд заасан хууль зүйн туслалцаа авах иргэдийн эрхийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор 2004-2006 онд ННФ санхүүжүүлэн Хэнтий аймаг болон Сонгинохайрхан дүүрэгт “Эрх зүйн туслалцааны төв”-ийг туршилтаар ажиллуулсан нь манай улсын хууль зүйн туслалцааны тогтолцоог бий болгох үндэс суурь болсон гэж үзэж болох юм. Үүний үр дүнд төлбөрийн чадваргүй иргэдийн эрхийг хамгаалах тусгай бүтэц бүхий нэгж байх нь зүйтэй төдийгүй хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэн Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх

Үндэсний хөтөлбөр” батлан 2007-2012 онд хэрэгжүүлсэн билээ. Монгол Улсад эрүүгийн хэрэгт холбогдон ял эдэлж буй хүмүүсийн 80 орчим хувь нь нэн ядуу, ядуу амьдралтай иргэд байгаа статистикт үндэслэн хөтөлбөрийн эрхэм зорилго нь “иргэдийн санхүүгийн байдлаас үл хамааран хууль зүйн туслалцааг тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлэх үндэсний тогтолцоог бий болгох явдал” гэж тодорхойлсон юм. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлсэн туршлага, хүний нөөц, материаллаг баазад түшиглэн төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлын эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр УИХ-аас Төлбөрийн

чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдан Хууль зүйн туслалцааны төв байгуулагдан орон даяар 35 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Ийнхүү хууль зүйн туслалцааны тогтолцоо бий болсон нь томоохон дэвшил болсон хэдий ч улсын өмгөөлөгчдийн цалин хангамж бага байдгаас өндөр ур чадвартай, туршлагатай өмгөөлөгчид тэр бүр энэ салбарт ажиллахгүй байна. Мөн Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн зохицуулалтаар зөвхөн эрүүгийн хэргийн яллагдагчид туслалцаа үзүүлж байгаа нь төлбөрийн чадваргүй хохирогчид болон



▲ Бүх нийтийн эрх зүйн боловсролд хуульчдын гүйцэтгэх үүрэг сэдэвт хэлэлцүүлэг, Про боно хуульчдын чуулга уулзалт, 2017 оны 12 сарын 8

бусад эмзэг бүлгийн иргэнийг энэхүү тогтолцооны гадна үлдээж байгаа юм.

Иймд 2017 оны 8 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран улсын өмгөөлөгчдийн анхны цугларалт семинар зохион байгууллаа. Тус арга хэмжээ нь байгууллагын хөгжлийг дэмжих зорилгоор баг хамт олныг бэхжүүлэх оролцоонд тулгуурласан семинар, урьдчилан авсан хэрэгцээ шаардлагын судалгааны дүнд үндэслэн шинээр батлагдсан эрүүгийн хууль тогтоомжийн, эмзэг бүлэгтэй харилцахтай холбоотой сэтгэл зүйн сургалт болон харилцан туршлага солилцох хэлэлцүүлгээс бүрдлээ. Түүнчлэн хууль зүйн туслалцааны эрх зүйн орчинд өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгаатай холбоотой шинэ хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцүүлжээ. Хэлэлцүүлгийн үр дүнд ННФ хууль зүйн туслалцааны дүн мэдээ, улсын өмгөөллийн үйлчилгээг үр дүнтэй удирдлага

зохион байгуулалтаар хангахад зориулж мэдээллийн нэгдсэн цахим сан бий болгох, хууль эрх зүйн орчныг сайжруулах замаар улсын өмгөөлөгчдийн статус болон Хууль зүйн туслалцааны төвийн тогтвортой үйл ажиллагаанд дэмжлэг болох үүднээс нэг жилийн хугацаанд тэтгэлэг олгоод байна.

Хууль зүйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд хуульчдын нийтэд тустай үйл ажиллагаа буюу про боно тодорхой хувь нэмэртэй болох нь олон улсын туршлагаас харагддаг. Тиймээс про боно үйл ажиллагааны талаарх хуульчдын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, хөхиүлэн дэмжих нь чухал байгаа юм. Энэ зорилгоор ННФ Азийн 6 дахь удаагийн про боно Бага хуралд Монголын хуульчдын холбоо (МХХ)-ны Нийтэд тустай үйл ажиллагааны хорооны гишүүн, өмгөөлөгч Ц.Одонжав, "Монгол өмгөөлөгч" ХХН-ийн өмгөөлөгч Т.Энхбулгантамир нарыг оролцуулсан нь энэ чиглэлийн үйл ажиллагааг

эхлүүлэх анхны алхам боллоо. Уг хурал 2017 оны 9 дүгээр сарын 30-аас 10 дугаар сарын 2-ны өдрүүдэд Малайз Улсын Куала Лумпур хотноо зохион байгуулагдсан юм. Хуралд оролцогчид олж авсан мэдлэг, мэдээлэлдээ тулгуурлан Монгол Улсад про боно үйл ажиллагааг дэлгэрүүлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах санаачилга гаргаснаар ННФ МХХ-ны Хуульчдын нийтэд тустай үйл ажиллагааны хороотой хамтран анхны Про боно хуульчдын чуулга уулзалтыг 2017 оны 12-р сарын 8-нд зохион байгууллаа. Уг арга хэмжээ нь олон улсын туршлагатай танилцах, хуульчдын про боно үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих арга замыг тодорхойлох, иргэний нийгэм, хуульчдын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой байв. МХХ-ны гишүүн хуульчид, орон нутгийн Хуульчдын холбооны салбар зөвлөлийн төлөөлөл, нийтийн эрх ашгийн төлөө, хүний эрхийг хамгаалах чиглэлд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэх иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, хууль зүйн сургуулийн багш, судлаачдаас бүрдсэн 100 гаруй хүн бүртгүүлж оролцсоныг дурдах нь зүйтэй.

Тус арга хэмжээний үндсэн илтгэлийг "Про-боно соёлыг түгээн дэлгэрүүлэх нь буюу дэлхийн чиг хандлага" сэдвээр Азийн про боно хөдөлгөөнийг үндэслэгчдийн нэг, Зүүн Өмнөд Азийн иргэдийн хууль зүйн боловсролын гүүр байгууллагын захирал Брюс Ласки тавьж, иргэдийн эрх зүйн боловсрол, нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах болон нийгмийн эмзэг бүлгүүдтэй ажиллахад про боно хуульчдын оролцоо зэрэг асуудлуудаар дэд хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

СОНГУУЛЬ, УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТ

2017 оны 6 сарын 26-нд болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явцад хяналт тавьсан төрийн бус байгууллагууд сонгуулийн бэлтгэл үйл ажиллагаа болон нэр дэвшигчдийн кампанит ажил ид өрнөдөг 6 дугаар сард долоо хоног бүр хэвлэлийн бага хурал зохион байгуулж сонгогчдод мониторинг болон ажиглалтын мэдээллээ шуурхай хүргэж ажиллалаа. ▶

Сонгуулийн тухай хуульд заасны дагуу Төрийн аудитын дээд байгууллагаас ээлжит сонгуульд нам, эвсэл тус бүрээс зарцуулах зардлын дээд хэмжээг 6,8 тэрбум, нэг нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 3,9 тэрбум төгрөгөөс хэтрүүлэхгүй байхаар тогтоосон. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн гурван нэр дэвшигчид мөрийн хөтөлбөрөө сонгогчдод сурталчлах, тайлбарлан таниулахад тус бүр **10,7 тэрбум** төгрөг зарцуулах боломж олгожээ. Сонгогчдын санал худалдан авах гэх мэт хууль бус үйл ажиллагаанд мөнгө зарцуулах аваас хүлээлгэх хариуцлагыг мөн хуульд тодорхой заасан. Харин энэ зүйл, заалт хэрэгжихийн тулд сонгуулийн санхүүжилт ил тод байж түүнд Төрийн аудит төдийгүй, иргэд хяналт тавих боломжтой байх ёстой.



Манай орны хувьд 2017 онд нийгэм, улс төрийн амьдралд тохиосон нэг чухал үйл явдал нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль байв. Улсын Их Хуралд суудал бүхий гурван намын нэр дэвшигч өрсөлдсөн уг сонгуулийн анхан шатны санал хураалт 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр тохиосон бөгөөд нэр дэвшигчдийн хэн нь ч дийлэнх олонхын санал аваагүй тул ардчилсан сонгуулийн түүхэнд анх удаа хоёрдугаар шатны санал хураалт явуулсан онцлогтой сонгууль болж өнгөрлөө. Нэр дэвшигчдийн сурталчилгаа Сонгуулийн тухай хуульд заасны дагуу 2017 оны 6 дугаар сарын 6-ны өдрөөс 24-ний өдрийг

дуустал үргэлжилсэн бөгөөд энэ хугацаанд бодитой мэдээлэл, дүн шинжилгээнд үндэслэсэн бодлогын мэтгэлцээн, нэр дэвшигчдийн танилцуулсан мөрийн хөтөлбөрийг тойрсон хэлэлцүүлгээс илүүтэй сөрөг сурталчилгаа давамгайлсны зэрэгцээ санал худалдан авах үзэгдэл өмнөх сонгуулиудтай харьцуулахад нэлээд газар авсан нь цаашид энэ асуудлыг зохицуулж буй эрх зүйн орчныг эргэн харж өөрчлөх зайлшгүй шаардлага байгааг илтгэж байв.

ННФ-ын зүгээс сонгуулийн үйл явцын ил тод байдлыг хангах, сонгууль шударга явагдахад иргэний нийгмийн хяналт тавих оролцоог дэмжих ерөнхий зорилгын хүрээнд (i) Хэвлэл

мэдээллийн мониторинг, (ii) сонгуулийн автоматжуулсан системийг сонгуульд бэлтгэх үйл явц болон (iii) сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг гэсэн гурван чиглэлээр сонгуулийн үйл явцад мониторинг хийсний зэрэгцээ сонгуулийн өдөр санал хураах, дүнг гаргах, техникийн буюу хяналтын тооллого хийхэд Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн байгууллагуудтай хамтран хөндлөнгийн ажиглалт хийж гүйцэтгэлээ.

Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторингийг Бодлогод Залуусын Хяналт ТББ, Захиргааны Шинэ Санаачилга ТББ хамтран гүйцэтгэсэн. Төслийн хүрээнд сонгуулийн кампанит ажил эхлэхтэй зэрэгцэн улс төрийн намуудад санхүүжилтээ ил тод тайлагнахыг уриалсан уриалга хүргүүлсэн ба сонгуулийн санхүүжилттэй холбоотой хууль тогтоомжийг сонгогчдод таниулах аяныг сошиал медиагаар өрнүүлсэн нь 40 мянга гаруй хүнд хүрчээ. Төслийн гол үйл ажиллагаа нь сонгуулийн санхүүжилтэд хяналт тавих чиг үүргийг хуулиар хүлээсэн СЕХ, АТГ, УАГ, ТЕГ зэрэг төрийн байгууллагуудад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа байсан ба энэ хүрээнд дээрх байгууллагуудад хандан Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд үндэслэн нэр дэвшигчдийн санхүүжилт, түүний зарцуулалттай холбоотой

мэдээллийг ил тод тайлагнах хүсэлтийг удаа дараа тавьж ажиллав. Үүний үр дүнд АТГ анх удаа сонгуулийн өдрөөс өмнө гурван нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг цахим хуудсандаа нийтэлж олон нийтэд ил болгосон нь сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах чиглэлд гарсан чухал дэвшил байлаа. Харин нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг авах хүсэлтийг СЕХ, УАГ-т хандан удаа дараа тавьсан боловч амжилт олоогүй юм. Ардчилсан Монгол Улсын иргэн төрийн байгууллагаас мэдээлэл авах эрхийг Үндсэн хуульдаа зааж, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулиар баталгаажуулсан байдаг. Хуулиар олгогдсон иргэдийн мэдэх эрх ийнхүү зөрчигдөх эрсдэл үүссэн тул мониторинг хийсэн төрийн бус байгууллагын зүгээс ХҮЭК-т эрхээ хамгаалуулахаар хандаж гомдол гаргасан. ХЭҮК гомдлыг хүлээн авч холбогдох төрийн байгууллагуудаас тодруулга авсны үндсэн дээр иргэний нийгмийн байгууллагад хуулиар олгогдсон мэдээлэл авах эрхийг ханган ажиллах зөвлөмжийг СЕХ-нд хүргүүлээд байна. ХЭҮК-ын хувьд анх удаа сонгуулийн санхүүжилттэй холбоотой мэдээлэл авах эрхийг зөрчсөн тухай гомдлыг хүлээн авч ийнхүү нааштай шийдвэрлэсэн нь цаашид улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахад иргэний нийгмийн хяналт тавих оролцоог хөхиүлэн

“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-нээс сонгогчдын боловсролд зориулан гаргасан мэдээллийн хуудсууд



дэмжсэн чухал ач холбогдолтой шийдвэр боллоо гэж үзэж байна.

Сонгуулийн санхүүжилтийн мониторингоос гадна сонгуулийн үйл явцын ил тод байдлыг ханган, зөрчил маргаанаас сэргийлэхэд гол нөлөөтэй гэж үзсэн хэдэн хэдэн чиглэлээр мөн “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ”-ний бусад гишүүн байгууллагатай хамтран 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явцад бие даасан хяналт тавилаа.

Тухайлбал, Сүлжээний гишүүн МИДАС ТББ нь сонгуулийн автоматжуулсан системд хөндлөнгийн мониторинг хийх ажлыг хариуцан ажилласан. Монгол Улс сонгуулийн санал тоолох автомат төхөөрөмжийг 2012 оны УИХ болон нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд анх ашигласан билээ. Үүнээс хойш сонгууль дөхөх бүр улс төрийн намуудын зүгээс автомат төхөөрөмжийн найдвартай ажиллагаанд эргэлзэн, шүүмжлэх хандлага ажиглагдаж ирсэн нь 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийг ч мөн тойрсонгүй. Иймд уг асуудлаар олон нийтэд баримт нотолгоотой бодит мэдээлэл хүргэхэд анхаарч МИДАС ТББ-ын мэргэжилтнүүд СЕХ-ны дэргэдэх Мэдээллийн технологийн ажлын хэсгээс санал тоолох төхөөрөмжүүдийг сонгуульд туршин бэлтгэх, баталгаажуулж, гэрчилгээжүүлэх ажлыг хөндлөнгөөс ажигласан ба төхөөрөмжүүдээс

санамсаргүй сонгож өөрсдийн боловсруулсан тестийн тавил, хувилбаруудаар бие даасан тест хийв. Сонгуулийн үеэр дээрх ажиглалт, туршилтын үр дүнг тухай бүр олон нийтэд шуурхай танилцуулахад ННФ дэмжлэг үзүүлж ажиллалаа.

2017 оны сонгуулийн сурталчилгаа нь дээр өгүүлсэнчлэн 2017 оны 6 дугаар сарын 6 -24-ний өдрүүдэд харьцангуй богино хугацаанд явагдсан. Сурталчилгааны үеэр сонгогчдод тэнцвэртэй үнэн зөв мэдээлэл хүргэж нэр дэвшигч, улс төрийн нам, эвслийн байр суурийг ойлгуулах, зөв сонголт хийхэд туслах чухал үүрэгтэй хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд ажиглалт хийхэд нь “Глоб Интернэшнл төв” ТББ-д дэмжлэг үзүүлээ. Мониторингийн хүрээнд үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлэг эрхэлдэг телевизийн таван сувгийн нийт 1691 цаг 13 минут 42 секундын хөтөлбөрт ажиглалт хийхэд 8,2 хувийг сонгуультай холбоотой мэдээлэлд зарцуулсныг мониторингийн тайланд дурджээ. Мониторингийн дүнгээс харахад нэр дэвшигчдийн тухай телевизүүдийн нэвтрүүлэгт тэнцвэртэй мэдээлэл ховор, хэт нэг талыг барьж туйлширсан байдал ихээр ажиглагдаж өмнөх сонгуулиудын алдааг давтсан аж. Түүнчлэн далд сурталчилгааны шинжтэй мэдээлэл нэлээд нэвтрүүлж, мэдээний хөтөлбөр нь нам, эвсэл, нэр дэвшигчдийн сурталчилгаа болон хувирч хуульд заасан сурталчилгааны

цагийн хязгаарыг хэтрүүлсэн зэрэг өмнөх сонгуулиудын сурталчилгааны явцад гарч байсан зөрчлүүд мөн л давтагдсан болохыг мониторингийн тайланд дурдан шүүмжилжээ.

Сонгуулийн үйл явцын хамгийн чухал үе шат нь санал хураах өдөр билээ. Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний сайн дурын 100 ажиглагч 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болсон нэгдүгээр шатны санал хураалт болон 7 дугаар сарын 7-ны өдрийн хоёр дахь шатны санал хураалтад ажиглалт хийлээ. Эхний шатанд Улаанбаатар хотын сонгуулийн 6 дүүргийн 50 хэсэгт буюу нийт хэсгийн 12 хувьд нь ажиглалт хийсэн бол хоёр дахь шатны санал хураалтын үеэр 20 сонгуулийн хэсэгт ажиллаж сонгуулийн санал хураах, тоолох, дүн гаргах үйл явц Сонгуулийн тухай хуулийн дагуу явагдаж буй эсэхэд ажиглалт хийлээ. Түүнчлэн 6 дугаар сарын 26-нд 50 хэсгээс 23-т нь, 7-р сарын 7-ны хоёр дахь шатны санал хураалтаар 20 хэсгээс 11-т нь хяналтын буюу техникийн тооллого явагдахад хөндлөнгөөс хяналт тавьлаа. Ийнхүү ажиглалт хийхэд саналын тоо зөрөх зөрчил гараагүй байна.

Энэхүү ажиглалтыг Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ болон Бодлогод залуусын хяналт ТББ хамтран зохион байгуулсан ба

ажиглалтын аргачлалыг 2004, 2008, 2009, 2012, 2016 оны сонгуульд ажиглалт хийсэн иргэний нийгмийн туршлага болон Азийн Чөлөөт Шударга Сонгуулийн Бүсийн сүлжээ мөн Филиппиний Чөлөөт Сонгуулийн Иргэдийн Үндэсний хөдөлгөөний ажиглалт хийх аргачлалд үндэслэн боловсруулсан юм.

ННФ-ын зүгээс сонгуулийн үйл явцад иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотой ийнхүү хяналт тавихаас гадна сонгууль, улс төрийн санхүүжилтийн асуудлаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, энэ асуудлаар сэтгүүлчдийн мэдлэгийг гүнзгийрүүлэх зорилгоор сэтгүүлчдийн клуб байгуулан, хамтран ажиллаж байгаа билээ. Энэ клубын гишүүн, 25-р суваг телевизийн Мэдээллийн албаны дарга Ерөнхий продюсер С.Насанжаргал, Ардын эрх сонины Ерөнхий эрхлэгч Ч.Гангэрэл, Үндэсний шуудан сонины Ерөнхий эрхлэгч С.Ононтуул нарын гурван сэтгүүлчийг 2017 оны 11 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд Өмнөд Африкийн Йоханнесбург хотноо болсон Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн 10 дахь удаагийн бага хуралд оролцоход нь

дэмжлэг үзүүлэв. Сургалт хэлбэрээр явагддаг уг бага хурал нь эрэн сурвалжлах болон дата анализын шинэлэг арга зүйг сэтгүүлчдэд танилцуулан чадавхыг нь бэхжүүлэх, улмаар мэргэжил нэгт нөхөдтэйгээ сүлжээ үүсгэн хамтран ажиллахад нь дэм өгөх зорилгын хүрээнд зохион байгуулагдсан юм.

Тэрчлэн улс төрийн нам, улс төрчдийн санхүүжилт, тэдний сонгуулийн зардал, хөрөнгө орлогын мэдүүлэг зэрэг мэдээллийг нэг дороос авах боломжтой www.shilennam.mn цахим хуудсыг агуулга, дизайны хувьд баяжуулан шинэчлэхэд анхаарч МИДАС ТББ-тай хамтран ажиллалаа. Тодруулбал, уг цахим хуудсанд 2016 оны УИХ-ын сонгуулийн дараа төрийн өндөр албанд шинээр томилогдсон хүмүүсийн хөрөнгө орлогын мэдүүлэг болон бусад мэдээллийг нэмж шинэчлээд байгаа ба улс төрчдийн эдийн засгийн сонирхол, санхүүжилттэй холбоотой асуудлаар сурвалжилж мэдээлэл бэлтгэх сонирхолтой сэтгүүлчид цахим хуудсын агуулгад сайн дураар хувь нэмэр оруулж болох техникийн шийдлийг хийж гүйцэтгээд байна.

“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-нээс сонгогчдын боловсролд зориулан гаргасан мэдээллийн хуудсууд



ТӨРИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

Иргэний нийгмийн байгууллагуудын санаачлан зохион байгуулсан нийтийн сонголд оролцсон хүний тоо



- Нийт оролцогчдын тоо
- Төрийн байгууллага
- Иргэд



▲ “Иргэний нийгмийн төрд хяналт тавих оролцоо, нийтийн эрх ашгийн өмгөөлөл” сэдэвт сургалтад оролцогчдыг бүлгийн үйл ажиллагааны явц, 2017 оны 8 сар

ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ МЕХАНИЗМ

2006 онд батлагдсан Авлигын эсрэг хуулиас хойш төрийн ил тод байдал, хариуцлагын механизмыг зохицуулж буй эрх зүйн орчинд томоохон дэвшил гарсан нь 2011 онд батлагдсан Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль, түүнчлэн 2012 оноос эхлэн хэрэгжиж буй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль юм. Үүний дараа шийдвэр гаргах

үйл явцад иргэдийн оролцоог баталгаажуулахад чухал нөлөөтэй Хууль тогтоомжийн тухай (2016), Захиргааны ерөнхий хууль (2015), Нийтийн сонголын тухай (2015), Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай (2016) хуулиуд тус тус батлагдан хэрэгжиж эхлээд 1-2 жилийн нүүр үзэж байна.

Дээрх хуулиудад төрөөс гаргаж буй бодлого, шийдвэрт иргэдийн оролцоог хангах

заалтууд тодорхой туссан бөгөөд иргэний нийгмийн байгууллагуудад төрийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд бүтээлчээр, үр дүнтэй оролцох боломж нээж өгсөн билээ. Тухайлбал, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд анх удаа иргэний нийгмийн байгууллагууд нийтийн эрх ашгийг хамгаалан шүүхэд нэхэмжлэл гаргаж болох заалт багтжээ. Тэрчлэн 2016 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн хэрэгжиж буй Нийтийн сонсголын тухай хуулиар иргэд, төрийн бус байгууллага, бусад хуулийн этгээд холбогдох төрийн байгууллагуудад сонсгол зохион байгуулах хүсэлт гарган хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт боловсруулахад байр сууриа илэрхийлэн оролцох боломжтой болсон. Үүний зэрэгцээ төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэхэд оролцох боломж бүрдсэн билээ.

Иргэдийн оролцооны цоо шинэ механизмуудыг бий болгосон дээрх хуулиудын хувьд цаашид засаж сайжруулах зүйл байгаа нь тодорхой боловч, юутай ч төрийн хариуцлагатай, ил тод байдлыг иргэдийн оролцоотойгоор нэмэгдүүлэх эрх зүйн таатай нөхцөл бүрдсэн гэж үзэх бололцоотой. Гэвч дээрх чухал хуулиудын хэрэгжилт нь

туйлын хангалтгүй байсаар ирлээ. Ийнхүү хэрэгжилт нь удаашрахад 2016 болон 2017 онд дараалан явагдсан сонгуулиуд нөлөөлсөн нь тодорхой боловч төрийн зүгээс хуулиудыг хэрэгжүүлэхэд анхаарч санаачилга гаргахгүй байгаа, мөн иргэний нийгмийн хувьд чадавх дутах байдал нөлөөлж буй нь гарцаагүй юм. Үүнтэй холбоотой ННФ-ын 2017-2020 оны стратегийн гол зорилгуудын нэг нь ерөнхийдөө дээр дурдсан чухал хуулиудын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэж байгаа юм.

Энэ зорилгын хүрээнд 2016 оны 7 дугаар сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг ашиглан нийтийн эрх ашгийг хамгаалах, төрөөс хариуцлага шаардах иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор “Иргэний нийгмийн төрд хяналт тавих оролцоо, нийтийн эрх ашгийн өмгөөлөл” сэдэвт цуврал сургалтыг 2017 оны эхний улирлаас эхлэн зохион байгуулж, нийслэл болон нийт 16 аймгийн 70 гаруй төрийн бус байгууллагын 100 гаруй төлөөллийг хамруулав. Уг сургалтаар Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай, Хууль тогтоомжийн тухай, Нийтийн сонсголын тухай болон Захиргааны ерөнхий хуулиудыг төрийн бус байгууллагууд үйл ажиллагаандаа үр дүнтэй ашиглах боломжийг танилцуулж мөн холбогдох мэдээлэл өгсөн юм. Улмаар сургалтын үр дүнг

баталгаажуулах зорилгоор 2017 оны сүүлийн хагасаас эхлэн уул уурхай, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах асуудлаар нийтийн эрх ашгийн өмгөөлөл хийх, түүнчлэн Нийтийн сонсголын тухай хуулийн хүрээнд сонсгол зохион байгуулах зэрэгт тэтгэлэгт хөтөлбөрүүд зарлагдав. Үр дүнд нь 2017 онд стратегийн өмгөөллийн хөтөлбөрт 11 төрийн бус байгууллага хамрагдан шүүхэд нийтийн эрх ашгийн нэхэмжлэл гарган ажиллаж байгаа ба эдгээрээс Заамар суманд олгогдсон тусгай зөвшөөрлийг цуцлуулах нэхэмжлэлийн шаардлага бүхий өмгөөллийн ажил тодорхой үр дүнд хүрээд байна (Дэлгэрэнгүйг энэ тайлангийн Олборлох салбарын засаглал болон Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь гарчгуудаас үзнэ үү.). Шинээр бий болсон эрх зүйн зохицуулалтыг ийнхүү туршин хэрэгжүүлснээр шүүхийн практик болон хуулийн зохицуулалтаас үүдсэн саад бэрхшээл, цаашид авч хэрэгжүүлэх нөлөөллийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоод байна.

2017 оны 8 дугаар сард эхэлсэн Нийтийн сонсголын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд нийт найман байгууллага тэтгэлэг авснаас долоо нь тус тусын сонгосон асуудлаар орон нутагтаа нийтийн сонсгол амжилттай зохион байгуулаад

байна. Тухайлбал, Говь-Алтай аймгийн ИТХ, Хөвсгөл аймгийн Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо ТББ Орон нутгийн хөгжлийн сангийн асуудлаар сонсгол зохион байгууллаа. Мөн Зүүн бүсийн хүний эрхийн төв Дорнод аймгийн Гурванзагал суманд, Экологи Өв Соёл ТББ Завхан аймгийн Улиастай хотод Газар зохион байгуулалтын асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран сонсгол зохион байгуулаад байна. Түүнчлэн Багануур дүүргийн Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын сүлжээ Багануурын уурхайн байгаль орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө, тайлан, нөлөөллийн үнэлгээний асуудлаар 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ИТХ-тайгаа хамтран тус дүүргийн хэмжээнд анхны нийтийн сонсголыг амжилттай зохион байгуулсан. Эдгээр сонсголд нийт 524 төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, иргэд оролцжээ.

Энэ хугацаанд Улаанбаатар хотод Утааны эсрэг аав ээжүүд ТББ агаарын бохирдлын асуудлаар сонсгол зохион байгуулах хүсэлтээ холбогдох төрийн байгууллагуудад хандан гаргаж нөлөөллийн үйл ажиллагаа явуулсан ч амжилтад хүрээгүй юм. Ерөнхийлөгчийн тамгын газар, УИХ, Байгаль орчны яам зэрэг байгууллагаас Утааны эсрэг аав ээжүүд ТББ-ын хүсэлтэд булзааруулсан

шинжтэй хариултууд ирүүлсэн нь Нийтийн сонсголын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх, улмаар цаашид сайжруулах шаардлагатай асуудлыг тодруулахад тустай байгааг дурдах нь зүйтэй.

Тэрчлэн ННФ-ын зүгээс нийтийн сонсголын тэтгэлэг авсан байгууллагуудын туршлага солилцох уулзалт 2018 оны 3 дугаар сарын 28-29-нд болж хууль хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлүүдийн талаар ярилцаж санал солилцов. Уг уулзалтаас харахад сонсголын зохион байгуулалт, хүлээгдэх үр дүнгийн талаар талууд жигд бус мэдээлэлтэй, хуулийг янз бүрээр ойлгож хэрэгжүүлж байгаа байдал ажиглагдсан юм. ННФ-аас зохион байгуулсан сургалтад хамрагдсан төрийн бус байгууллагуудын хувьд сонсгол зохион байгуулахаас өмнө иргэдэд хуулийг танилцуулах, сонсголд оролцохоор хүсэлт гаргасан хүмүүст тусгайлан сургалт явуулах, төрийн байгууллагуудад хандсан нөлөөлөл явуулах, сонсгол зохион байгуулах шийдвэр гаргуулах гэх мэтээр ажиллажээ. Харин сургалтад хамрагдаагүй, мэдээлэл багатай байсан байгууллагуудын хувьд сонсгол, хэлэлцүүлгийн ялгааг ойлгоогүй, төрийн байгууллагын үүргийг оролцогчоос ялгахгүй байх гэх мэт асуудлууд гарсан байна.

2011 онд батлагдсан Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд иргэдийн

мэдээлэл хайх, олж авах эрхийг баталгаажуулан мэдээлэл авах гэж буй зорилгыг нь лавлахыг хориглож, ил тод байх ёстой мэдээллээ гаргаж өгөхөөс цааргалсан албан хаагчийг ажлаас халах хүртэл хариуцлага тооцохоор заасан билээ. Гэтэл уг хууль хэрэгжиж эхлээд даруй 6 жил өнгөрч байхад төрийн албан хаагчид мониторинг хийх гэж байгаа төрийн бус байгууллагад хууль бус шаардлага, шалгуур тавьж, мэдээлэл өгөхөөс цааргалсан хэвээр байгаа нь төрийн үйл ажиллагаа ил тод байх талаарх төрийн албан хаагчдын ойлголт, хандлагад дорвитой өөрчлөлт гараагүй болохыг илтгэн харуулж байна. Мэдээллийн ил тод байдлын тухай хууль нь ННФ-ын бүх хөтөлбөрүүдэд хамаатай тул хөтөлбөр тус бүрийн хүрээнд уг хуулийг хэрэгжүүлэх практик бий болгох, улмаар хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн ажлууд зохион байгуулж ирсний зэрэгцээ бие даасан төсөл мөн хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2014 оноос эхлэн Нээлттэй Нийгэм Сангуудын санхүүжилтээр “Иргэд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ баталгаажуулахад туслах нь” төслийг (STRIPE) хэрэгжүүлэн тодорхой үр дүн гараад байна (Дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь гарчгийн “Туул голыг хамгаалах захирамж, шийдвэрийн хэрэгжилт” сэдвээс үзнэ үү.).

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ НЬ



▲ Нээлттэй Нийгэм Сангуудын Азийн бүсийн Захирал Бинайфер Новрожи төрийн бус байгууллагуудын ажилтнуудтай уулзаж, ажлын байртай нь танилцлаа, 2017 оын 9 сар

ниймийн байгууллагуудаас оффисын байрны нэн тэргүүн хэрэгцээтэй дор дурдсан 6 байгууллагыг сонгож нийт 291,3 м.кв талбайг эзэмшүүллээ. Үүнд:

- Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн ТББ
- Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн ТББ
- Хил хязгааргүй алхам ТББ
- Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ
- Захиргааны шинэ санаачилга ТББ
- Ардчиллын боловсрол төв (DEMO) ТББ.

Манай улсад ардчиллыг бэхжүүлж хөгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, нийтийн эрх ашгийг хамгаалах, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд иргэний нийгмийн байгууллагууд идэвх зүтгэл гарган ажиллаж, үнэтэй хувь нэмэр оруулж байна. ННФ нь иргэний нийгмийн энэхүү үйл ажиллагааг дэмжих чиглэлээр тууштай хүчин чармайлт тавьж

ирсэн билээ. Энэ чиглэлээр 2017 онд дорвитой алхам хийх боломж бүрэлдэж 6 иргэний нийгмийн байгууллагад анх удаа байгууллагын хөгжлийн дэмжлэг үзүүлж оффисын байраар хангалаа.

Нийтийн эрх ашгийг хамгаалах эрхэм зорилготой, хөгжлийн урт хугацааны стратегитэй, сайн засаглалын зарчмуудыг чухалчлан хэрэгжүүлдэг иргэний

Форум нь уг байрыг худалдан авах, оффисын өрөө болгож хуваах, нийтийн зориулалтаар ашиглах уулзалтын танхим, бусад талбайг тохижуулах зэрэгт нийт 250,000 ам. доллар зарцуулсан болно. Эдгээр байгууллага нь 2017 оны 9 сараас эхлэн шинэ байрандаа орсон бөгөөд эхний ээлжинд 5 жилийн хугацаанд ашиглах эрхтэйгээр эзэмшиж байгаа болно.



▲ Оффисийн байр хүлээн авах гэрээнд төрийн бус байгууллагын захирлууд гарын үсэг зурж 5 жилийн хугацаанд ашиглах эрхээ баталгаажуулав. 2017 оны 6 сар

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААР ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ НЬ

Иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ эдлэхийн тулд амьдарч буй нутаг орныхоо байгаль орчин, усны нөөц, бохирдлын хүчин зүйлс зэрэг мэдээллийг авах боломжоор хангагдах ёстой. 2014 оноос эхлэн Нээлттэй Нийгэм Сангуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр ННФ иргэдийн энэ эрхийг баталгаажуулахад нь туслах төслийг Дэлхийн нөөцийн хүрээлэн олон улсын байгууллагын арга зүйн дэмжлэгтэйгээр Монгол Улсад хэрэгжүүлж ирлээ.

Уг төслийн хоёр дахь шат 2016 оны 10 дугаар сараас эхлэн 2017 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд байгаль орчны бохирдолд өртсөн Хан-Уул дүүргийн 12, 13, 14-р хороо болон Төв аймгийн Заамар сумын иргэдийн оролцоонд тулгуурлан үргэлжилсэн юм. 2017 оны 8 дугаар сараас




▲ Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн малчин өрх
2017 оны 5 сарын 4

төслийн гурав дахь шат эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд Байгаль орчин, эрүүл мэнд төв, Ил тод байдал сан, Хөвсгөл Далайн Эзэд хөдөлгөөн зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ Олборлох салбарын засаглал хөтөлбөртэй хамтран “Төлсөн авснаа нийтэл” эвслийн

гишүүдийг татан оролцуулж, төсөлд хамрагдах орон нутаг, нөлөөллийн цар хүрээг өргөжүүллээ.

Мөн 2017 оны хувьд хэд хэдэн онцлох асуудлаар хамтарсан нөлөөллийн үйл ажиллагааг явуулаад байна.



▲ Төв аймгийн Заамар сумын удирдлагаас төрийн бус байгууллагын захидалд өгсөн хариу, 2017 оны 5 сарын 4

АЛТ 2 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙН ЭСРЭГ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛЛАГАА



▲ Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн нутагт ажиллаж байгаа алт угаах хөдөлгөөнт үйлдвэр, 2017 оны 5 сарын 5

Монгол Улсын Засгийн газар 2017 оны 1 дүгээр сарын 18-нд “Алт 2” үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлж эхэлсэн нь манай төсөл хэрэгжиж буй Заамар сумын иргэдийн өдөр тутмын амьдралд шууд нөлөө үзүүлсэн. 1994 оноос тус сумын Заамарын нурууны ар хэсэгт хэрэгжүүлсэн “Алт 1” хөтөлбөр нь орон нутгийн хөгжилд нэмэр болохоосоо илүү байгаль орчны доройтол, малчин иргэдийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлсээр ирсэн.

“Алт 2” хөтөлбөрийн хүрээнд тус сумын Төмөстий багийн нутаг дэвсгэрт буюу Заамарын нурууны өвөр хэсэгт нийт 21,000 га талбайд ашигт

малтмалын тусгай зөвшөөрөл олгосон нь нутгийн малчин иргэд мал аж ахуйгаа эрхлэн аж төрөх нөхцөлгүй болгосон шийдвэр болжээ. Заамар сумын иргэдийн төлөөлөгчийн хурлаас энэхүү тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг дэмжихгүй гэсэн тогтоол гаргаж, улмаар уг газрыг сум, аймгийнхаа тусгай хэрэгцээний газарт авч хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохгүй байхаар шийдвэрлэсээр атал үүнийг үл ойшоон хууль бусаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон явдлыг орон нутгийн удирдлага, малчид эсэргүүцэн тэмцсэн юм. Энэхүү үйл ажиллагаанд Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн ТББ үндэсний

хэмжээний нөлөөлөл явуулах, нийтийн эрх ашгийн үүднээс шүүхэд нэхэмжлэл гаргах, Ил тод байдал сан ТББ сумын орон зайн зураглал гаргах зэрэгт дэмжлэг үзүүлж, хамтран ажиллалаа. Үүний үр дүнд 2017 оны 1 дүгээр сард Ашигт Малтмалын Газрын захирамжаар тусгай зөвшөөрлөөр олгогдсон 21000 га газрын хэмжээг 5.3 дахин багасгаж чадлаа. Нутгийн малчид, иргэдийн эрх ашгийг хамгаалахаар Бургаст Туул, Бугат Заамар ТББ манлайлан хууль бус уул уурхайн үйл ажиллагаа, байгалийн нөөцийн хэрэглээнд мониторинг, баримтжуулалт хийж байна. Энэ талаарх мэдээллийг www.baigalorchin.mn цахим хуудаснаас харна уу.

ТУУЛ ГОЛЫГ ХАМГААЛАХ ЗАХИРАМЖ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ



▲ Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн малчин өрхийн амьдралын орчны хэсгийг ухсан байдал, 2017 оны 5 сар

“Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь” төслийн хүрээнд 2014 оноос эхэлсэн нөлөөллийн ажлын үр дүнд УИХ-ын Өргөдлийн байнгын хороо 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдөр дараах утга бүхий тогтоол гаргалаа. Туул голын ай сав газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохгүй байх, тусгай зөвшөөрөл эзэмшигч нөхөн сэргээлт хийгээгүйн улмаас байгаль орчинд хохирол учруулах, хүний амь нас, мал, амьтан эрстэх, лицензийн наймаа, бусад хууль бус үйл ажиллагаанаас сэргийлж, хууль бус үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн түгээмэл

тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх чиглэлийг 02 дугаар тогтоолоор Засгийн газарт өгсөн болно.

Нийслэлийн Засаг даргын А/609 дугаартай захирамжийн дагуу Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй, тусгай зөвшөөрөл бүхий ашиглалтын талбай нь Улаанбаатар хотын ундны усны хамгаалалтын бүсэд орсон 62 аж ахуйн нэгж, байгууллагын түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан. Мөн түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай

зөвшөөрөл олгосноос хойш 3 жилийн хугацаанд ашиглаж эхлээгүй 33 аж ахуйн нэгж, байгууллагын газрын хэвлий ашиглах эрхийг дуусгавар болгосон. Тогтоолууд гарснаас хойш Туул голын сав газар, түүний ойр орчимд элс, хайрга олборлохыг бүрэн зогсоосон бөгөөд төрийн холбогдох байгууллагууд 2017 онд шинээр тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн аваагүй гэсэн мэдээлэл өгч байгаа юм.

Гэсэн хэдий ч нутгийн иргэдийн төлөөллөөс бүрдэх Шинэ суурьшил Эрүүл аюулгүй орчин ТББ хайрга дайрга олборлогчид хууль бусаар олборлолт хийсээр байгааг, нөхөн сэргээлт хийгээгүйн улмаас аюултай нөхцөл байдал хэвээр үргэлжилсээр байгааг баримтжуулж эрх бүхий байгууллагад өргөдөл, гомдол гаргах, нийтийн эрх ашгийн үүднээс шүүхэд нэхэмжлэл гаргах зэргээр тэмцлээ үргэлжлүүлсээр байна.

Түүнчлэн 2017 оны 5 дугаар сард манай улсад ажилласан НҮБ-ын Хүрээлэн буй орчин, хүний эрхийн тусгай илтгэгч Жон Нокст төслийн хүрээнд хийсэн баримтжуулалтаар дамжуулж Монгол Улсын иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх хэрхэн зөрчигдөж байгааг танилцуулсан нь олон улсын нөлөөллийн томоохон алхам болж чадлаа. Түүний НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд илгээсэн албан ёсны тайлан, зөвлөмжид

Монгол Улсын Засгийн газар байгаль орчныг хамгаалах бодлого, стандартыг цаасан дээр гаргаад орхих биш газар

дээр нь хэрэгжүүлэхэд анхаарч, холбогдох нөөц боломжийг бүрдүүлэн ажиллах, байгаль орчны асуудлаар бодлого

боловсруулахад иргэний нийгмийн оролцоо чухал болохыг онцгойлон дурджээ.

ОРЧНЫ ОРОН ЗАЙН ЗУРАГЛАЛААР ДАМЖУУЛАН ИРГЭДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ

Ил тод байдал сан ТББ “Байгаль орчны мэдээллийн ил тод, нээлттэй байдлын загвар” боловсрууллаа. Үүний үр дүнд Монгол Улсын байгаль орчны эрх зүйн зураглал ба хэрэгцээ шаардлагын судалгаанд үндэслэн орон нутгийн иргэдэд нэн чухал шаардлагатай 8 төрлийн мэдээллийн агуулга, түүнийг орон нутгийн түвшинд ил тод, нээлттэй болгох арга хэлбэрүүдийг нэг бүрчлэн тодорхойлж загварчиллаа. Энэхүү мэдээллийн агуулгыг Төв аймгийн Заамар сум ба Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 13-р хорооны жишээн дээр харуулсан болно. Эдгээр орон нутгийн байгаль орчинд хамаарах албан ба албан бус

мэдээллийг хоёр жил гаруйн хугацаанд системтэйгээр цуглуулснаар тэнд үүссэн нөхцөл байдал, өөрчлөлт, бохирдол түүнд нөлөөлсөн болон нөлөөлж буй хүчин зүйл, шийдвэр, байгууллага хүмүүсийн талаарх иж бүрэн мэдээллийн сан үүсгээд байна.

Байгаль орчны мэдээллийг орон зайн зураглал (газрын зураг)-д түшиглэж, түүнийг ил тод байдлын эхлэх цэг болгон ашиглаж эхэлсэн нь чухал үр дүн юм. Энэхүү арга нь аливаа байршлыг солбицлоор тогтоож баталгаажуулах, орон нутгийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ шаардахад тустай бодитой баримт, нотолгоо болж байна. Өөрөөр хэлбэл, Монгол

орны байгаль орчны мэдээллийн хэт төвлөрсөн, зөвхөн албан ёсны цөөн эх сурвалжаас хамааралтай, голдуу цаг хугацааны хувьд хоцорсон үйл явдлын тайлан, үр нөлөө багатай ерөнхий статистик мэдээллийн санг өөрчлөхөд бодитой алхам боллоо.

Энэхүү зураглалыг гаргахдаа зөвхөн хиймэл дагуулын зургаас гадна иргэдийн оролцоотойгоор газар нутгийн нарийвчлалыг гаргаж, шаардлагатай тэмдэглэл зэргийг нэмснээр илүү ач холбогдолтой болдог. Энэ аргыг байгаль орчны хувьд эрсдэлд ороод байгаа газар нутгуудад иргэдийн хүсэлт, захиалгаар хийж эхлээд байна.



▲ Төв аймгийн Заамар сумын иргэд, сумын засаг даргатай хийсэн уулзалт, 2017 оны 5 сарын 4

ОРЧНЫ БОХИРДЛЫГ ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Байгаль орчин, эрүүл мэнд төв нь 2016 оноос эхлэн Байгаль орчны бохирдлын нэгдсэн мэдээллийн талаар судалгаа шинжилгээний ажлыг хийж ирлээ. Энэ хүрээнд Хан-Уул дүүргийн 12, 13-р хороод болон Төв аймгийн Заамар сум орчмын 16 аж ахуйн нэгжээс гарч буй хаягдлыг газар дээр нь очиж олон улсын туршлагатай харьцуулан судалсан юм. Энэ явцад үйлдвэрүүдийн үүсгэж байгаа бохирдлын талаар тодорхой мэдээлэл авах эрх тэр орчмын оршин суугч иргэдэд төдийгүй нутаг дэвсгэрийн төрийн

байгууллагын ажилтнуудад ч одоо мөрдөж буй хууль тогтоомжоор олгогдоогүй байгаа нь тодорхой болов. Түүнчлэн аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагааныхаа явцад гаргаж буй хаягдлын талаар тэр орчмын оршин суугч иргэдэд мэдээлж байх үүрэг ч хүлээгээгүй байна.

Өнгөрсөн хугацаанд “Орчны бохирдлын эх үүсвэрт өнгөт кодоор хяналт хийх аргачлал”, аж ахуйн нэгжийн хог, хаягдлыг (агаар, ус, хөрсөнд хаягдах) мэдээлж байх маягтуудыг боловсруулж бодлогын шийдвэр гаргуулахаар БОАЖЯ-д

хүргүүлээ. Мэдээллийн маягтуудыг боловсруулснаар нэгдсэн дүн мэдээ гаргах боломж бүрдэж, амьдарч буй орчинд нь үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, аж ахуйн нэгжид иргэд хяналт тавихаас гадна, орчноо цэвэр, бохирдолгүй байхад анхаардаг болно гэж үзжээ. Түүнчлэн иргэдийн хэрэгцээнд нийцсэн орчны мэдээллийн сан бий болгох боломжтой.

Цаашид дээр дурдсан аргачлалыг турших, иргэдэд танилцуулах сургалт, сурталчилгааны ажлуудыг хийж гүйцэтгэх зайлшгүй шаардлага гарч байна.

УСНЫ ЗАСАГЛАЛ

Монгол Улсын усны нөөц 2021 он гэхэд хомсдолд орно гэсэн хэтийн төлөв байгааг БОАЖЯ албан ёсоор зарлаж усны засаглалыг сайжруулах чиглэлд ахиц дэвшил гаргах оролдлого хийхгүй байна. Дэлхий дахинаа усны хомсдолыг багасгахын тулд НҮБ-аас 2017 оныг “Хаягдал усны” хэмээн зарласан.

Усны засаглалын хувьд төрийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх механизм хангалтгүй, зөв бүтэц, зохион байгуулалт, мэргэжлийн хүмүүсийн оролцоо, мэдээллийн нэгдсэн сан, жигд мэдээллээр хангах, байгууллага хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй байна. Хамгийн гол нь усны засаглалын чухал зарчим болох олон нийт, иргэдийн оролцоог хангах бүтэц байхгүй байгаа юм. Өнөөдрийн байдлаар усны

менежментийг 29 сав газрын захиргааны бүтцээр дамжуулж хэрэгжүүлэхээр тодорхойлсон боловч үйл ажиллагаа нь шаардлагын хэмжээнд хүртэл жигдрээгүй байна.

Байгаль орчин, эрүүл мэнд төвийн санаачилгаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Усны бодлогын зөвлөх, БОАЖЯ, Усны Үндэсний Хороо, ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн, ДЭЗФ-ын дэргэдэх 2030 Усны Нөөцийн Бүлгийн Монгол дахь төлөөлөгч зэрэг бодлого боловсруулах шатны институтууд, эрдэмтэн судлаачид, байгаль орчны зөвлөх компанийн удирдлага зэрэг усны бодлого боловсруулалт, зохицуулалт, хэрэгжүүлэлт, хяналт, үнэлгээний чиглэлээр ажиллах үүрэгтэй талуудын дунд хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион

байгуулж, усны засаглалын зарчим, ойлголтыг жигдлэх алхам хийгээд байна.

Тус төслийн арга зүйн хамтрагч Дэлхийн Нөөцийн хүрээлэнгийн ажилтан, хөтөлбөрийн захирал Кэрол Эксел, Элизабет Мозес нар 2017 оны 5 дугаар сард манай улсад ажиллаж төслийн өмнөх шатны үнэлгээг хийж орон нутгийн иргэд, БОАЖЯ-ны холбогдох албаны хүмүүстэй уулзлаа. Энэхүү томилолтын мөрөөр “Шударга ёсоор цангах нь: Ил тод байдал ба Индонези, Монгол, Тайландын ядуу иргэдийн цэвэр усны төлөө тэмцэл” (*Thirsting for Justice: Transparency and Poor People's Struggle for Clean Water in Indonesia, Mongolia, and Thailand*) төслийн тайлан хэвлэгдэн гарлаа.



ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР

2017 ОНД

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Олборлох салбарын гэрээний ил тод байдал, нийтийн өмгөөллийн сэдвээр **60 гаруй** төрийн бус байгууллага ННФ-ын санхүүжилт, аргазүйн дэмжлэгтэйгээр ажиглалт, мониторинг хийв.



ОЛБОРЛОХ САЛБАРЫН ЗАСАГЛАЛ



Салбарын засаглалд 2017 онд ил тод байдлыг хангахад чиглэсэн зарим нааштай өөрчлөлт гарсны нэг нь Монгол Улс 2006 оноос хэрэгжүүлж ирсэн Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОУИТБС)-ын хэрэгжилтийг олон улсад үнэлүүлж, “хангалттай ахиц дэвшил” гаргасан дэлхийн 2 дахь улс болсон явдал юм. Түүнчлэн эрдэс баялгийн салбарын гэрээнүүдийн болон ашиг хүртэгч эздийн мэдээллийг олон нийтэд ил тод болгох ажлын эхлэл тавигдлаа. Тухайлбал, Нээлттэй засаглалын түншлэлийн Үндэсний төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд

дээрх мэдээллүүдийг ил тод болгох ажил тусгагдан хэрэгжих нөхцөл бүрдэж байна. ННФ-ын санаачилгаар бий болсон Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санг (www.iltodgeree.mn) өргөжүүлэх, практикт бий болсон гэрээний ил тод байдлыг хуульчлан баталгаажуулах чиглэлээр ННФ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) болон Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын алба “Хамтран ажиллах санамж бичиг”-т гарын үсэг зурлаа. Талуудын хооронд байгуулагдсан уг санамж бичгийн хүрээнд Ажлын хэсэг байгуулагдан эрдэс баялгийн салбарт байгуулагддаг 12 төрлийн 400 орчим гэрээг цуглуулан, гэрээний мэдээллийн

◀ УУХҮЯ болон ННФ хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах ёслолтын ажиллагаа

Баруун гар талаас УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Дамба, ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг, ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга Ж.Ганбаатар, Астериск технологис ХХК-ийн Гүйцэтгэх захирал А.Отгонбаяр

2017 оны 6 дугаар сарын 22-ны өдөр. УУХҮЯ-ны байр, Хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах ёслолтын ажиллагаа ▶

цахим санд байршуулахаар ажиллаж байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн “ашиг хүртэгч жинхэнэ эзэн” буюу эцсийн өмчлөгчийг ил тод болгох асуудлаар талуудын байр суурь нэгдэж “ашиг хүртэгч эзэн”-ийн хууль зүйн тодорхойлолт, ил тод болгох мэдээллийн цар хүрээг ОУИТБС-ын Үндэсний зөвлөлөөр хэлэлцэн баталлаа. Түүнчлэн Ашигт малтмалын тухай, Улсын бүртгэлийн тухай, Татварын ерөнхий хуулиудад өөрчлөлт орсноор “ашиг хүртэгч эзэд”-ийн бүртгэл мэдээллийг хөтөлж, хяналт тавих эрх зүйн орчин бүрдлээ.

Гэсэн хэдий ч нийгэм, эдийн эдийн засгийн томоохон үр дагавар бүхий бодлогын чухал шийдвэрүүдийг батлан гаргахдаа хуулиар шаардсан тооцоо судалгааг зохих ёсоор хийхгүй, хэлэлцүүлэг өрнүүлж, санал шүүмж авахгүй байх явдал энэ салбарт хэвшил болох хандлагатай байна. Тухайлбал, 2017 онд батлагдсан Алт-2

хөтөлбөр, тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журамд орсон өөрчлөлт зэрэг нь олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх хуулийн шаардлагыг зөрчин батлагджээ. Ялангуяа Алт-2 хөтөлбөрөөс улбаалсан иргэдийн эрхийг зөрчсөн хууль бус шийдвэр, үйл ажиллагааг эсэргүүцсэн тэмцэл хөдөлгөөнүүд орон нутагт цөөнгүй гарах боллоо.

Түүнчлэн ОУИТБС-ын дүнд бий болсон “ил тод байдал”-ыг авлига, ашиг сонирхлын зөрчлийг таслан зогсоох, урт хугацааны, тогтвортой хөгжилд чиглэсэн бодлого боловсруулахад илүү үр дүнтэй ашиглах сорилт цаашид тулгамдсан асуудал хэвээр байна. Энэ нь зөвхөн төрийн холбогдох байгууллагууд ОУИТБС-ын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, бодлого, шийдвэр боловсруулахдаа ашиглах төдийгүй иргэний нийгмийн байгууллагууд ч баримт, судалгаа тооцоонд үндэслэсэн бодлогын хувилбарыг

санал болгоход ОУИТБС-ын мэдээллийг бүрэн дүүрэн ашиглах тухай асуудал юм. Дээрх нөхцөл байдлыг харгалзан 2017 онд эрдэс баялгийн салбарын засаглалын ил тод байдлыг гүнзгийрүүлэхэд олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг бодит ажил хэрэг болгох, иргэний нийгмийн үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах, ил тод хариуцлагатай байдлын чиглэлээрх эрх зүйн орчинд гарсан ахиц дэвшлийг бататган хамгаалах үндсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүллээ. Энэ хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудад зориулан бодлого боловсруулахад илүү дүнтэй оролцох чадавх бэхжүүлэх сургалт, хэлэлцүүлгүүд зохион байгуулж, зорилтот тэтгэлэг олгож ажилласнаас гадна гэрээний болон ашиг хүртэгч эздийн ил тод байдлыг хангах асуудлаар эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлууд хийж ирлээ.





▲ 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан “Уул уурхайн тухай хууль: Ил тод байдал” сэдэвт хэлэлцүүлэг



▲ 2017 оны 2 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдсан “Уул уурхайн тухай хууль: Уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлт” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр УУХҮЯ-ны Ажлын хэсгийн гишүүн Д.Жавхланболд хуулийн төсөл дэх байгаль орчныг хамгаалахтай холбоотой заалтуудыг танилцууллаа.

2017 онд төрөөс эрдэс баялгийн салбарын эрх зүйн зохицуулалтад томоохон өөрчлөлт хийх үйл явц өрнүүлсэн нь ННФ-ын зүгээс ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх чиглэлээр хийж буй нөлөөллийн ажлаа эрчимтэй явуулахад түлхэц боллоо. 2014-2016 онд боловсруулж УИХ-д өргөн барьсан Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг эргүүлэн татаж, ил тод байдлын асуудлыг бие даасан бүлэг болгож Уул уурхайн тухай хуулийн төсөлд багцлан тусгасан боловч гэрээ болон эздийн ил тод байдал, иргэдийн оролцоо зэрэг олон чухал асуудлыг орхигдуулсан байв. Тиймээс ННФ нь Төлсөн авсанаа нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвсэлтэй хамтран УУХҮЯ-

аас боловсруулж буй хуулийн төслийг иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулан санал шүүмж авах цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж, “Ил тод байдлыг хангах”, “Тусгай зөвшөөрөл олгох, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах”, “Уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлт” зэрэг сэдвээр гурван багц санал шүүмж бэлтгэн хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт хүргүүлээ.

Хуулийн төсөлд өгсөн иргэний нийгмийн санал шүүмж нь тусгай зөвшөөрөл болон газар, ус ашиглах эрх олгох, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ батлах, гэрээ хэлцэл байгуулах зэрэг уул уурхайтай холбоотой чухал шийдвэрүүдэд



▲ 2017 оны 2 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдсан “Уул уурхайн тухай хууль: Уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлт” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр УУХҮЯ-ны Ажлын хэсгийн гишүүн М. Дагва хуулийн төсөл дэх уурхайн хаалттай холбоотой заалтуудыг танилцууллаа.

иргэдийн оролцоог хангахад чиглэгдсэн юм. Тухайлбал, Уул уурхайн тухай хуулийн төсөл төдийгүй Ашигт малтмалын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай зэрэг салбарын гол хуулиудыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх замаар “Сонсох ажиллагаа”-г хэрэгжүүлэх хууль эрх зүйн боломжийг бүрдүүлэх чиглэлээр санал өглөө. Тэрчлэн ил тод байдлыг зөвхөн ашигт малтмалын ашиглалтын үйл



▲ 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан “Уул уурхайн тухай хууль: Ил тод байдал” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр “Оюу толгойн хяналт” ТББ-ын тэргүүн Д.Сүхгэрэл санал, шүүмж хэлж байгаа нь.

ажиллагаагаар хязгаарласан нь ОУИТБС-ын өнөөг хүртэл хэрэгжиж ирсэн цар хүрээг хумьж, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны гэрээлэгчийн ил тод байдлыг хангах үүрэг, хариуцлагыг бууруулах эрсдэлтэй болохыг анхаарууллаа.

Үүний үр дүнд эрдэс баялгийн салбарт “захиргааны гэрээ” гэсэн ойлголтыг хүлээн зөвшөөрч, гэрээ байгуулах үйл



▲ 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан “Уул уурхайн тухай хууль: Иргэдийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлэг дээр ТАН эвслийн гишүүн Транспарэнси Интернэшнл байгууллагаас Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явц дахь авлигын эрсдэлийн үнэлгээний тайлангаа танилцуулав.

явцад “Сонсох ажиллагаа”-г хэрэгжүүлэх, байгуулсан гэрээгээ нийтэд ил тод болгох заалтыг хуулийн төсөлд тусгаад байна. Мөн компаниуд ил тод байдлын тайландаа “ашиг хүртэгч эзэд”-ийн мэдээллээ тусгах, төрөөс түүнийг нь хянан баталгаажуулж, нийтэд ил тод болгох зохицуулалтыг ч хуулийн төсөлд тусгууллаа. Цаашид хуулийн төсөлд тусгагдсан иргэний нийгмийн саналуудыг хамгаалан батлуулах нөлөөллийн ажлыг үргэлжлүүлэн хийх болно.

Түүнчлэн ашиг хүртэгч эздийн ил тод байдлыг хангах чиглэлээр 2016 онд хийсэн судалгааны тайланд үндэслэн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын дунд нийт 9 удаа хэлэлцүүлэг зөвлөгөөн зохион байгуулсны дүнд “ашиг хүртэгч эзэд”-ийн талаарх хууль зүйн ойлголт, тодорхойлолт дээр талууд нэгдсэн байр суурьтай боллоо. Цаашид энэ чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэхэд ОУИТБС-ын Үндэсний зөвлөлөөс баталсан дээрх хууль зүйн тодорхойлолт, ил тод байдлын цар хүрээг баримтлах юм.

Анх 2015 онд ННФ болон Төлсөн авсанаа нийтэл (ТАН) эвслийн орон нутагт хэрэгжүүлсэн үйл

ажиллагаанд үндэслэн ОУИТБС-ын орон нутгийн дэд зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг баталж байсан билээ. Тэгвэл 2017 онд Засгийн газраас тогтоол гаргаж, орон нутгийн дэд зөвлөлийн үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэхээр болсон нь ил тод байдлын санаачилгыг орон нутагт бодитой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлээ.

Түүнчлэн төрийн ил тод, нээлттэй байдлын чиглэлээр эрх зүйн орчинд гарсан ахиц дэвшлийг сахин хамгаалах, аливаа ухралт, хууль зөрчсөн үйл ажиллагаанд шуурхай хариу үзүүлэх бүтэц бий болгох зорилгоор иргэний нийгмийн хяналтын бүлэг /watchdog/ байгуулан ажиллуулж

байна. ТАН эвслийн гишүүн байгууллагуудаас тодорхой удирдамжийн дагуу ээлжлэн хэрэгжүүлж буй тогтмол хяналтын үндсэн дээр өнгөрсөн онд нийт 7 удаа уулзалт-хэлэлцүүлэг зохион байгуулж, уул уурхай, газрын тосны үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмуудад санал шүүмж өгөөд байна. Үүний үр дүнд УУХҮЯ, Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) зэрэг төрийн холбогдох байгууллагууд аливаа хэм хэмжээ тогтоохдоо Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтээр хэлэлцүүлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрч, ТАН эвсэлтэй хамтран ажиллаж хэвшээд байна.



▲ Хууль тогтоомж, бодлого судалгааны төвийн захирал Д.Тэгшбаяр олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниудын хуулийн мэргэжилтнүүдтэй хийсэн хэлэлцүүлгийн үеэр “ашиг хүртэгч эзэд”-ийн ойлголт, хууль зүйн тодорхойлолтыг танилцуулж байгаа нь.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ



▲ 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр, ОНХАГ-ний хэрэгжилтийн мониторингийн үр дүнг олон нийтэд танилцуулах уулзалт



▲ Уулзалтын үеэр төрийн бус байгууллагууд мониторингийн төслийнхөө үр дүнг танилцуулж байгаа нь.

Төрийн ил тод нээлттэй байдалд хяналт тавих иргэний нийгмийн үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор дараах 4 асуудлаар нэгдсэн удирдамжийн дагуу иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийлээ.

Булган аймгийн Бүрэгхангай, Дундговь аймгийн Баянжаргалан, Өмнөговь аймгийн Цогтцэций, Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Завхан аймгийн Дөрвөлжин, Төв аймгийн Заамар сумд болон Сүхбаатар аймагт хэрэгжсэн ОНХАГ-нд заасан иргэдийн оролцооны журмын мониторингийн дүнгээс харахад орон нутагт гэрээ байгуулахад Захиргааны ерөнхий хуульд заасан “сонсох ажиллагаа”-ны хэрэгжилт маш хангалтгүй байна. Гэхдээ мониторингийн үр дүнд 2018 онд Төв аймгийн Заамар

сум гэрээ байгуулахдаа “сонсох ажиллагаа”-г анх удаа хийсэн, Сүхбаатар аймагт гэрээний хэрэгжилт сайжирч, гэрээний дагуу хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийг иргэдэд нээлттэй мэдээлж хэвшсэн зэрэг нааштай өөрчлөлтүүд гарчээ. Тэрчлэн ОНХАГ-ний хэрэгжилтээр хийсэн иргэний нийгмийн нэгдсэн мониторинг нь гэрээ байгуулах, түүний хэрэгжилтийг хянах, дүгнэх үйл явцыг журамлах, салбарын хууль тогтоомжийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх хэрэгцээ, шаардлагыг нотлон харуулж ОУИТБС-ын Үндэсний зөвлөлөөс гэрээний үйл явцыг журамлах Ажлын хэсэг байгуулахад нөлөөллөө.

Иргэний нийгмийн 6 байгууллагын хамтран хэрэгжүүлсэн төрийн өмчит уул уурхайн компаниудын

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн мониторингоор худалдан авалтын төлөвлөгөө, тайлан, худалдан авах үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдал хангалтгүй байгааг илрүүлж, холбогдох талуудад нөлөөлөл хийснээр Эрдэнэс Монгол ХХК-ийн худалдан авалтын мэдээлэл сайжирч, Эрдэнэт үйлдвэр ХХК шилэн дансны цахим хуудсаа шинэчлэн хуулиар шаардсан 7 төрлийн мэдээллийг ил тод болгож эхэлсэн зэрэг нааштай өөрчлөлтүүд гарчээ. Түүнчлэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх мониторингийн нэгдсэн арга зүй бий болсон нь цаашид энэ чиглэлээр төрийн бус байгууллагууд бие даан ажиллах боломжийг бүрдүүлж байна.


Гол мөрний хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт явагдаж байгаа уул уурхайн үйл ажиллагааны нөхөн сэргээлтийн гэрээний хэрэгжилтийн мониторингоор Төв аймгийн Заамар, Алтанбулаг, Дархан-Уул аймгийн Шарын гол, Хонгор сумд, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 16 компанийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийлээ.

Мониторингийн дүнгээр усан сан бүхий газрын хамгаалалтын бүсэд ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд хуульд заасны дагуу нөхөн сэргээлтийн гэрээ хийдэггүй, гэрээ байгуулсан ч хэрэгжүүлдэггүй, хэрэгжүүлэхгүй байсан ч холбогдох талууд хяналт тавьж, хариуцлага тооцдоггүй зэрэг олон зөрчил дутагдлыг илрүүлээ. Энэ нь Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоолын дагуу 5 талт гэрээ байгуулах үйл явц нь өөрөө их төвөгтэй бөгөөд орон нутагт гэрээний мэдээлэл хүрдэггүй тул газар дээр нь хяналт тавих боломжгүй болдог зэргээс шалтгаалдаг ажээ. Тиймээс мониторингийн үр дүнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-аас гэрээний загвар, гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих журмыг боловсронгуй болгох ажлыг төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр болов.

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээний мониторингоор 2015-2016 онд байгуулсан нийт 35 гэрээний хэрэгжилтийг авч үзлээ. Мониторингийн дүнгээр энэ төрлийн гэрээний хэрэгжилт туйлын хангалтгүй байгаа нь харагдсан бөгөөд гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжид алданги хариуцлага тооцсон тохиолдол байхгүй байна. 2017 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар мониторингид хамрагдсан улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлаа нөхөн төлөх нөхцөлтэй 35 гэрээний 50 хүрэхгүй хувь (45,7%) л гэрээнд заасан төлбөрөө бүрэн гүйцэд төлж акт үйлдэж баталгаажуулсан байна. Бусад 19 гэрээний нөхцөл зохих ёсоор биелэлгүй үлджээ.

Төлбөр огт төлөөгүй болон хугацаа хэтэрсэн өглөгтэй компаниудад алданги тооцож, хариуцлага хүлээлгээгүйгээс 2015-2017 онд орлогын биелэлт дунджаар 52.8 хувьтай байна. Ийнхүү хайгуулын зардлын нөхөн төлбөрийн орлогын биелэлт хангалтгүй байхад АМГТГ-аас жил бүр орлогоо давуулан биелүүлдэг хэмээн тайлагнасан нь бодит байдлаас хол зөрүүтэй байгаа юм. АМГТГ-аас мониторингийн дүгнэлт зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхээ мэдэгдсэн төдийгүй гэрээтэй холбоотой журам, гэрээний загварыг


“Төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээний хэрэгжилт” мониторингийн дүн



- Төлбөрөө төлж акт үйлдсэн
- Төлж байгаа боловч хугацаа хоцорч байгаа
- Огт төлөөгүй 2 жил болсон

Иргэний нийгмийн байгууллагуудын хийсэн мониторингийн сэдвүүд:

- ОНХАГ дэх иргэдийн оролцооны журмын хэрэгжилт
- Төрийн өмчит уул уурхайн компаниудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
- Гол мөрний хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт явагдаж байгаа уул уурхайн үйл ажиллагааны нөхөн сэргээлтийн гэрээний хэрэгжилт
- Төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээний хэрэгжилт.



▲ Нийтийн эрх ашгийн нэхэмжлэлийн үр дүнд багасгасан талбай бүхий тусгай зөвшөөрлийн байршлын зураг: 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 111 тоот шийдвэрээр Төв аймгийн Заамар суманд олгогдсон 3921.28 га талбай бүхий XV-20880 тоот тусгай зөвшөөрлийн байршил

боловсронгуй болгох ажлыг 2018 онд хийж эхлээд байна.

Төрийн бус байгууллагуудад хуулиар олгогдсон нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах шинэ боломжийг ашиглан хариуцлага, шударга ёсыг тогтоох, чадавх бэхжүүлэх хүрээнд “Иргэний нийгмийн төрд хяналт тавих оролцоо, нийтийн эрх ашгийн өмгөөлөл” сэдэвт цуврал сургалтыг Төрийн ил тод, хариуцлагатай байдал хөтөлбөртэй хамтран зохион

байгууллаа (Энэ тайлангийн Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм сэдвээс дэлгэрүүлж үзнэ үү). Үүний үр дүнд уул уурхай, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр 11 төрийн бус байгууллага шүүхэд нэхэмжлэл гарган ажиллаж байна. Тэрчлэн шүүхийн хэрэг дээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор Хуульчдын зөвлөх бүлэг байгууллаа.

Захиргааны хэргийн шүүхэд гаргасан нийтийн эрх ашгийн нэхэмжлэлүүдээс Заамар суманд олгогдсон тусгай зөвшөөрлийг цуцлуулах нэхэмжлэлийн шаардлага бүхий өмгөөллийн ажил тодорхой үр дүнд хүрээд байна. Өмгөөллийн үр дүнд тусгай зөвшөөрлөөр 15 000 га газар олгосон байсныг 3400 га болгон бууруулсны зэрэгцээ Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журамд хууль бусаар оруулсан нэмэлт өөрчлөлтийг цуцлуулж чаджээ.



▲ Түгээмэл эрх хөгжил ТББ-аас хийсэн нийтийн эрх ашгийн өмгөөллийн хүрээнд Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын малчин иргэд нөлөөллийн үйл ажиллагаанд оролцож байгаа нь

Түүнчлэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хууль бусаар баталсан БОАЖЯ-ны шийдвэрийг хүчингүй болгуулж, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох суманд явагдаж байсан хууль бус уул уурхайн үйл ажиллагааг зогсоосон зэрэг үр дүн гарчээ. Нийтийн эрх ашгийн өмгөөллийн хүрээнд Хөвсгөл аймагт явуулсан нөлөөллийн ажлууд нь Цагаан-Уул суманд Дэлгэр мөрний эхэнд олгогдсон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлуулж, улмаар Хөвсгөл аймагт 50 дугаар өргөргөөс урагш газар нутгийг бүхэлд нь орон нутгийн тусгай хамгаалалтад авахад нөлөөлжээ.

Гэсэн хэдий ч хууль бус шийдвэр гаргасан, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах нэхэмжлэлүүдийн дийлэнх нь шүүхийн шатанд гацаж, үр дүн нь удааширч байна. Энэ нь нэг талдаа нийтийн эрх ашгийн өмгөөллийн талаарх шүүхийн ойлголт хандлага хангалтгүй, нөгөө талдаа төрийн бус байгууллагын чадавх, хуульчдын дэмжлэг, хамтын ажиллагаа дутмаг байгаатай холбоотой билээ. Иймээс цаашид энэ чиглэлээр шүүх, төрийн бус байгууллага, олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, хуульчдын идэвх

оролцоог нэмэгдүүлэх нь чухал юм. Тиймээс хуульчдыг нийгэмд тустай сайн дурын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор Иргэдийн эрх зүйн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Про боно хуульчдын чуулга уулзалтыг зохион байгууллаа. Чуулганы үеэр нийтийн эрх ашгийн өмгөөлөлд тулгарч байгаа бэрхшээл, хуульчдын үүрэг оролцооны талаар хэлэлцэж, тодорхой шийдлүүдийг ярилцсаны дотор цаашид энэ чиглэлээр ажиллах сонирхолтой хуульч, өмгөөлөгч нартай хамтын ажиллагаа тогтоолоо.



Нөлөөллийн үйл ажиллагаандаа баримт, дүн шинжилгээ ашиглах чадавхтай болгох зорилгоор мэдээлэл боловсруулах ур чадвар олгох цуврал сургалтыг Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнтэй хамтран зохион байгуулж, төрийн бус байгууллага, сэтгүүлчдийг хамрууллаа. Сургалтаар олж авсан ур чадвараа ашиглан ОУИТБС-ын тайлан, өгөгдөлд дүн шинжилгээ хийх ажлыг энэ онд үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна.

ОНХАГ-ний асуудлаар орон нутагт чадавх бэхжүүлэх сургалтыг Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнтэй хамтран

төвийн болон хойд бүсэд зохион байгуулав. Сургалтад Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Ховд, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Төв аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын Газар, иргэний нийгмийн байгууллагуудаас 60 гаруй хүн хамрагдлаа. Хэлэлцээ хийх, иргэдийн оролцоог хангах, гол нөхцөлийг тодорхойлох, хэрэгжилтийг дүгнэх зэрэг гэрээний агуулга, үйл явцыг багтаасан дээрх сургалтын цогц модулийг цаашид онлайн хэлбэрт оруулах замаар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

▲ 2017 оны 12 дугаар сард зохион байгуулагдсан Про боно хуульчдын чуулга уулзалт, “Нийтийн эрх ашгийн өмгөөлөл: Хуульчдын үүрэг оролцоо” сэдэвт салбар хуралдаанд оролцогчид

Эрдэс баялгийн салбарт сайн засаглалын төлөө ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд улам чадавхжиж үйл ажиллагаа нь тогтворжин институцийн зохион байгуулалтад орж, ОУИТБС-ын үйл ажиллагаанд нөлөө бүхий оролцогч тал болж хүлээн зөвшөөрөгдөөд байна. Төлсөн авсанаа нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвсэл, түүний гишүүд нь төв орон нутагт тогтвортой үйл ажиллагаа явуулж төрийн бодлого, шийдвэрт оролцох, хяналт мониторинг хийх, өмгөөлөл нөлөөллийн ажил явуулах, чадавх бэхжүүлэх зэргээр идэвхтэй ажиллаж байна. Үүний үр дүнд ил тод байдал, оролцоог дэмжсэн дүрэм, журмууд батлагдан гарч, хууль ёс, хариуцлагыг шаардан нэхэмжлэх жишиг туршлага нэмэгдэж байгааг тэмдэглэж хэлэх нь зүйтэй. Цаашид ийнхүү нэгэнт бий болсон мэдлэг туршлага, байр суурь, хамтын ажиллагаандаа тулгуурлан ил тод байдлыг бодит хариуцлага болгоход илүү анхаарч ажиллах шаардлага үүсэж байна. Иймээс гэрээ болон эздийн ил тод байдал зэрэг тодорхой асуудалд төвлөрөн ил тод байдлыг шаардахаас гадна тоо баримт, мониторинг, дүн шинжилгээнд үндэслэн өмгөөлөл, нөлөөлөл, олон нийтийг хамарсан компани ажил зохион байгуулах зэргээр бодит хариуцлага, өөрчлөлтөд



▲ 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан “Уул уурхайн тухай хууль: Ил тод байдал” сэдэвт хэлэлцүүлэг

чиглэсэн ажлуудыг цаашид түлхүү авч хэрэгжүүлэхээр болсон нь эвслийн стратегид гарсан томоохон өөрчлөлт болоод байна.

Сүүлийн үед Алт-2 хөтөлбөртэй холбоотойгоор гарч буй иргэдийн эрхийг зөрчсөн хууль бус шийдвэр, үйл ажиллагааг эсэргүүцсэн тэмцэл хөдөлгөөнүүд орон нутагт ихээр гарах боллоо. Нутгийн иргэдийн хувьд мэдээлэл, хууль эрх зүйн мэдлэг дутмагаас эсэргүүцлийн үйл ажиллагаа нь хэвлэлийн бага хурал, суулт, жагсаал цуглаан хийхээс хэтрэхгүй байгаа бөгөөд иргэдийн энэ үйлдэлд төрийн байгууллагууд анхаарал хандуулж, арга хэмжээ авахгүй байна. Орон нутагт олгосон тусгай зөвшөөрөл,

нөхөн сэргээлт, хандив, тусламж, хөрөнгө оруулалт, ажлын байр зэрэг орон нутгийн иргэдэд чухал хэрэгцээтэй тоо баримтууд ОУИТБС-ын тайланд тусдаг боловч иргэд тэр бүр мэддэггүйгээс гадна цаг хугацааны хувьд хуучирсан, бараг 2 жилийн өмнөх мэдээлэл байдаг учраас зөрчил дутагдлыг илрүүлж, хариуцлага тооцоход хэрэглэгдэхгүй байна. Тиймээс ТАН эвсэл нь цаашдаа уул уурхайн асуудлаар орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад зөвлөн туслах “төв” болон хөгжих зорилт тавин ажиллаж эхэллээ.

ТАН эвсэл орон нутгийн иргэдийг чадавхжуулах зорилгынхоо хүрээнд ННФ-ын 2014 оноос Дэлхийн нөөцийн

хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн байгаль орчны мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь буюу STRIPE” төсөлд хамрагдан Дорноговь аймгийн Айраг, Сэлэнгэ аймгийн Ерөө, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумдад нутгийн

иргэдийг мэдээллээр ханган, эрхээ хамгаалах чадавхыг нь бэхжүүлэх ажлыг хийхээр боллоо. ТАН эвслийн гишүүн гурван байгууллагын хэрэгжүүлэх уг төсөл нь STRIPE төслийн хүрээнд бий болсон иргэдийн байгаль орчны мэдээлэл авах

эрхийг хангах арга зүй ба ОУИТБС-ын орон нутгийн дэд зөвлөлд тулгуурлан уул уурхай, газрын тосны үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрх, байгаль орчны зөрчлийг арилгуулах чадавхыг орон нутагт бий болгох зорилготой юм.



ТАН эвсэл нь *Responsible Mining Index* олон улсын байгууллагатай хамтран уул уурхайн компаниудын хариуцлагатай байдлыг үнэлэх индекс боловсруулах хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уг индексийн дагуу дэлхийн уул уурхайн томоохон компаниудын үйл ажиллагаа, хариуцлагатай байдлыг үнэлэх бөгөөд үүнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Рио Тинто компани хамрагдах юм. *Responsible Mining Index* байгууллагаас 2018 онд дээрх судалгааны үр дүнг танилцуулах болно.

▲ ТАН эвслийн гишүүд 2018-2020 оны үйл ажиллагааны стратегия боловсруулж байгаа нь, 2017 оны 11 сар



▲ STRIPE төслийн хамтрагч Дэлхийн нөөцийн хүрээлэнгийн ажилтнууд Дундговь аймагт ажиллаж, уул уурхайн үйл ажиллагаатай танилцлаа, 2017 оны 5 сар

ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО




Монгол Улсад төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдэж байгаа ч энэ нь эргэлт буцалтгүй үйл явц болоогүйн дээр цаашид хэрэгжилтэд онцгой анхаарч, хариуцлагыг сайжруулах шаардлага тулгарч байна. Төр засгаас холбогдох хууль хэрэгжүүлэх дүрэм журмыг цаг тухайд нь гаргахгүй байх, хэрэгжих хугацааг хойшлуулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хариуцлагын механизмуудыг сулруулах алхмууд хийгдэж байна. Тухайлбал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд удаа дараалан өөрчлөлт оруулж

ирсний улмаас сүүлийн жилүүдэд төсөв ихээхэн хэмжээний алдагдалтай батлагддаг болсноор төсвийн хуримтлагдсан алдагдлын хэмжээг улам бүр нэмэгдүүлж түүнийг цаашид санхүүжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсэв. Засгийн газар төсөв тэлэх бодлого баримталж, төсвийн алдагдлаа нөхөх зорилгоор дотоодын болон гадаадын их хэмжээний бондыг жил дараалан гаргаснаас гадна төсвийн орлогын нэлээд хэсгийг бүрдүүлдэг уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний үнэ огцом унаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс буурсан зэргээс үүдэн эдийн засагт

◀ Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих иргэний нийгмийн зөвлөгөөний үеэр Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд мониторинг хийсэн төрийн бус байгууллагуудын төлөөлөл мэдээлэл хийж, туршлага солилцов. 2017 оны 11 сар

Хоёр жил тутамд хийгддэг төсвийн ил тод байдлын үнэлгээнд бүх аймаг, нийслэл, түүний дүүргүүдийг хамруулан үр дүнг танилцууллаа. Энэ удаагийн үнэлгээнд дүүргүүдийг шинээр хамруулсан нь судалгааны цар хүрээг өргөтгөв. Түүнчлэн иргэний нийгмийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд орон даяар тасралтгүй хяналт тавьж, дүнг төр засаг, олон нийтийн анхааралд оруулж ажилласнаар энэхүү хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр төрөөс 2017 онд шинээр тогтоол, шийдвэрүүд гаргав.



Шилэн дансны мэдээллийн мониторингийн дүн

Шилэн дансны тухай хуулийн дагуу нийтэд ил тод болговол зохих мэдээллүүдээс зургаан төрлийн мэдээллийг сонгон авч аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрууд хэрхэн ил тод мэдээлж байгаад орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд ажиглалт хийн мониторингийн дүнг сар бүр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр танилцуулав. Засаг даргын Тамгын газрууд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээнд холбогдох шийдвэрийг ил тод болгох байдал нэн хангалтгүй байгаа нь харагдав.

Мониторингийн дүнг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

хүндрэл үүсэж өрийн дарамтад ороод байна. Иймд төсвийн сахилга батыг сайжруулах нь манай улсын хувьд нэн чухал.

ННФ Монгол улс дахь төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад нөлөө үзүүлэх, төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтуудыг үйл ажиллагааныхаа стратегид байнга тусган ажиллаж ирлээ. Энэ ажлын хүрээнд төсвийн ил тод байдлыг үнэлэх, төсвийн чиглэлээр ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, мониторингийн төсөл хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, төсвийн хууль эрх зүйн орчныг шинэчлэхэд иргэний нийгмийн дуу хоолойг тусгах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Төрөөс хуулийн хэрэгжилтийг хангах, ялангуяа засаглалыг сайжруулахад чиглэсэн хуулиудын хэрэгжилтийг хангахад төсөв хөрөнгө хуваарилах, холбогдох хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох зэрэг хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээг орхигдуулж ирсэн. Иймд бид 2015 оноос эхлэн төсвийн ил тод байдлыг хангахад чиглэсэн хуулиуд, ялангуяа Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад иргэний нийгмийн хүчин чармайлтыг хандуулах, энэ хүрээнд орон даяар нэгдсэн арга зүй, зохион байгуулалтын дор мониторинг хийн цогц нөлөөллийн үйл ажиллагаа явуулж байна.

2017 онд бид төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг хангах зорилго бүхий хуулиудын хэрэгжилтийг сайжруулахад иргэний нийгмийн идэвхтэй оролцоог бий болгохыг зорьж төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг хангах чиглэлээр үүрэг хүлээсэн төрийн хяналтын байгууллагуудтай иргэний нийгмийн зүгээс хамтран ажиллах, хуулийн дагуу хүлээсэн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь чиглэсэн нөлөөллийн ажлуудыг дэмжив. Тухайлбал, ННФ-аас иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран төсвийн төлөвлөлт, зарлага, худалдан авалтын ил тод байдлыг зохицуулж буй хууль, журмуудын хэрэгжилтийг үнэлсэн орон нутгийн төсвийн ил тод байдлын судалгааны дүнг танилцууллаа. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хэрхэн хангаж байгаад иргэний нийгмийн байгууллагуудын хийсэн хяналт мониторингийн үйл ажиллагааг дэмжин үр дүнг нь нэгтгэн олон нийтэд хүргэлээ. Мөн төсвийн нээлттэй, хариуцлагатай байдлын чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах сургалт, зөвлөгөөн зохион байгуулав. Шинээр бий болсон ил тод байдал, хариуцлагын механизмуудыг иргэний нийгмийн ажилтнуудад танилцуулж тэдгээрийг ашиглахад нь дэмжлэг үзүүлэв. Бид төсвийн болон мэдээллийн ил тод байдлын холбогдох хууль эрх зүйн баримт бичигт үндэслэн

2015 онд боловсруулсан улсын болон орон нутгийн төсвийн үйл явцын цахим цаглабарыг (www.forum.mn/tsaglabar/index.php) үргэлжлүүлэн ажиллуулж, Засгийн газар, аймаг, нийслэлээс

эхлээд төсвийн байгууллагуудын захирагчдын төсөв боловсруулах, хэлэлцэх, батлах, тайлагнах зэрэг үйл ажиллагааны хуваарийг иргэд, олон нийт мэдэх боломжийг бүрдүүлэв.

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МОНИТОРИНГ

Төсвийн захирагчид төсөв, санхүүгийн мэдээллээ ил тод болгож буй байдалд 2015 оноос эхлэн иргэний нийгмийн 30 гаруй байгууллага орон даяар нэгэн зэрэг гурван ч удаа тус бүр 6 сарын туршид тасралтгүй ажиглалт мониторинг хийж, дүнг нэгтгэн үндэсний болон орон нутгийн хэмжээнд олон нийтэд хүргэж байсан нь Шилэн дансны тухай хууль хэрэгжихэд чухал түлхэц үзүүлээ.

Шилэн дансны мэдээлэл нийтлэх явц 2015 оны сүүлээс 2016 оны эхний хагас жилд харьцангуй хэвшиж байсан боловч 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш хуулийн хэрэгжилт суларсан. Энэ нь улс, орон нутгийн төр засгийн байгууллагын ажилтнууд шинээр томилогдсонтой холбоотой гэж дүгнэж болохоор байсан юм. Тиймээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шинээр томилогдсон удирдлага, ажилтнууд хангаж ажиллахад нь нөлөөлөх чиглэлээр иргэний нийгмийн байгууллагууд үргэлжлүүлэн ажиллах шаардлагатай болсон

билээ. Ингээд 2016 оны 12 дугаар сараас 2017 оны эхний хагас жил дуустал хийсэн энэ удаагийн мониторингид бүх аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, ЗДТГ-ууд болон зарим төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийг хамруулав. Эдгээр ЗДТГ-ууд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, орлого, зарлагын гүйлгээ, шийдвэр зэргээ ил тод мэдээлж байгаа байдлыг ажиглан үр дүнг олон нийтэд хүргэж ажиллалаа. ЗДТГ-уудын нийтэлсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн дансны хуулгатай харьцуулж үзэн мэдээллийг бүрэн гүйцэд ил болгож байгаа эсэхийг тодорхойлов. Мониторингид хамрагдсан газруудын ихэнх нь худалдан авалт, орлого, зарлагын гүйлгээ болон түүнд хамаарах шийдвэрийн ил тод байдлыг сайжруулах шаардлагатай байгаа нь харагдав. Сангийн яамны зүгээс Төрийн сангийн сар бүрийн дансны хуулгыг бидний



Аймгуудын ЗДТГ-ын Шилэн дансны мэдээлэлд хийсэн мониторингийн дүнгээр 4 цуврал инфографик гаргав.



Нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ын Шилэн дансны мэдээлэлд хийсэн мониторингийн дүнгээр 4 цуврал инфографик гаргав.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 2017 онд төр засгийн зүгээс гаргасан тогтоол, шийдвэрүүдээс:



Засгийн газрын 89 дүгээр тогтоолоор "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" шинэчлэгдэв.



САНГИЙН ЯАМ

Сангийн яамны Төрийн сангийн газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлийг орон нутгийн төрийн сангуудад өгөв.

хүсэлтээр ирүүлж байсан нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилд ихээхэн тус дэмжлэг болсон юм.

Иргэний нийгмийн байгууллагууд ийнхүү орон даяар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, мониторинг хийн үр дүнг төр засаг, олон нийтийн анхааралд хүргэснээр төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий энэхүү хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тогтоол, шийдвэрүүд гарав. Тухайлбал, 2017 оны 3 дугаар сард Засгийн газрын 89 дүгээр тогтоолоор шинэчлэгдсэн "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-аар захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд багтах үзүүлэлтүүдэд "шилэн дансны хөтлөлт"-ийг багтаав. Энэхүү журмыг үндэслэн Засгийн газрын гишүүд, агентлагийн

дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал боловсруулан баталж мөрдүүлэх үүрэг хүлээж байгаа юм.

Мөн Үндэсний Аудитын газар 2017 оны сүүлээр төсвийн 100 гаруй байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар хугацаатай даалгавар өгч, биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцохоор болов. Цаашилбал, Сангийн яамны Төрийн сангийн газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлийг орон нутгийн төрийн сангуудад өгсөн байна. Үүнд, 5 сая төгрөгөөс дээш төлбөрийг үндэслэх баримт болон тушаал, шийдвэрүүдийг шилэн дансны нэгдсэн системд байршуулах шаардлагыг багтаажээ. Эдгээр нааштай өөрчлөлтийг иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс хийсэн тасралтгүй мониторингийн үр дүнгийн илрэл гэж үзэж болно.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Орон нутгийн төсвийн зарлага 2016 оны байдлаар 2.2 их наяд төгрөг буюу нэгдсэн төсвийн нийт зарлагын 27 хувийг эзэлж байна. Орон нутагт төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсвийн захирагчдын хариуцлагыг дээшлүүлэхэд төсвийн ил тод, нээлттэй байдал нэн чухал юм. ННФ 2011 оноос эхлэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран орон нутгийн төсвийн нээлттэй байдлын үнэлгээг бүх аймаг, нийслэлийг хамруулан хоёр жил тутамд хийж, төсвийн нээлттэй байдлыг сайжруулахад чиглэсэн Зөвлөмж гаргаж ирлээ. Энэхүү судалгаагаар орон нутгийн төсвийн ил тод байдал бүх үе шатанд хэрхэн хангагдаж буйд иж бүрэн үнэлгээ хийдэг билээ. Тухайлбал, орон нутгийн төсвийн төлөвлөлт, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг бүхий л үе шатны процедурыг үнэлгээнд хамруулдаг юм.

2013 онд хийгдсэн хоёр дахь удаагийн судалгаанаас хойш Шилэн дансны тухай хууль батлагдаж төсвийг ил тод болгох хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй төр засгийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох хууль эрх зүйн орчин бүрдсэн билээ. Орон нутагт уг хууль хэрэгжсэнээр бодит өөрчлөлт гарч буй эсэхийг

тодорхойлохыг зорьж төсвийн ил тод байдлын ээлжит үнэлгээг хийн 2017 онд үр дүнг танилцуулаад байна.

Судалгааны дүнгээр Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон холбогдох журмууд дахь төсвийн ил тод байдлыг зохицуулж буй заалтуудын хэрэгжилт аймаг, нийслэлийн хувьд дунджаар 39 хувьтай гарч өмнөх түвшнээс зөвхөн гурван хувиар дээшилжээ. Эндээс харахад төсвийн мэдээллийн ил тод байдал орон нутагт ерөнхийдөө хангалтгүй хэвээр байна. Түүнчлэн, нийслэлийн дүүргүүдийн төсвийн ил тод байдлыг анх удаа үнэлж үзэхэд дундаж үнэлгээ 31 хувьтай гарсан нь аймаг, нийслэлийн дунджаас 8 хувиар доогуур үзүүлэлт байв.

Судалгаанд хамрагдсан төсвийн 12 үйл явц болон баримт бичгүүдээс төсвийн гүйцэтгэл, батлагдсан төсвийг ил тод болгох үйл явц харьцангуй дээгүүр түвшинд байна. Харин дараа оны төсвийн төсөл, орон нутгийн хөгжлийн сан, засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын мэдээлэл харьцангуй хаалттай буюу ил тод байдлын үнэлгээ доогуур байгаа нь харагдав. Орон нутагт төсвийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлснээр

“Орон нутгийн төсвийн ил тод байдал 2016” судалгааны дүнгээс

“Орон нутагт дараа оны төсвийн төсөл, орон нутгийн хөгжлийн сан, засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын мэдээлэл хамгийн хаалттай байна.”



2016 оны байдлаар аймаг, нийслэлийн дунджаар төсвийн ил тод байдал 2013 онтой харьцуулахад гурван хувиар дээшилсэн ч нийт авбал зохих 100 хувиас 39 хувийг л авч чаджээ.



“Орон нутгийн төсвийн ил тод байдал 2016” судалгааны тайланг бүрэн эхээр нь www.forum.mn сайтаас үзнэ үү.

Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдал

2016 оны байдлаар аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлаар зөвхөн 3 аймаг 50%-иас дээш хувийн үнэлгээтэй гарав.



Нийслэлийн дүүргүүдийн төсвийн ил тод байдал

2016 онд дүүргүүдийн төсвийн ил тод байдлыг анх удаа үнэлэхэд Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон холбогдох журмуудын хэрэгжилт дунджаар 31 хувьтай байв.



мэдээлэлтэй иргэн олширч тэр хэрээр төсвийн үйл явцад бүтээлчээр оролцох буюу төсөв боловсруулах, хэлэлцэн батлах үе шатанд санал өгөх, төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийн үе шатанд хяналт тавих замаар төсөвт оролцох нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн ил тод байдал хангалтгүй байгаагийн гол шалтгааныг дурдвал:

- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих журам батлагдаагүй
- ИТХ-ын болон төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт сул
- Төсвийн үйл явцын болон баримт бичгийн ил тод байдлыг хангаагүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Шилэн дансны тухай хуульд тусган хуульчилсан ч хуулийн хэрэгжилтийг холбогдох этгээдүүд тухай бүр хянаж, үнэлэхгүй байгаагаас хариуцлагын механизм үйлчилдэггүй
- Мэдээллийг ил тод болгох үүрэг бүхий албан тушаалтнууд гаргасан мэдээллээ цахим хуудсанд нийтлэхэд цаг хугацаа алддаг зэрэгтэй холбоотой хэмээн үзэж байна.

Орон нутагт төсвийн ил тод байдлыг дээшлүүлэх чиглэлээр гаргасан зөвлөмжөөс

- Төсвийн ил тод байдлыг зохицуулсан хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг сайжруулах;
- Орон нутгийн түвшний эрх зүйн баримт бичигт төсвийн ил тод байдлыг хангах шаардлагыг тодорхой тусган зохицуулах;
- Төсвийн нээлттэй байдалд Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Иргэдийн нийтийн хурлаас тавих хяналтын журмыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлан мөрдөж ажиллах;
- Төсвийн ил тод байдалд цахим хэлбэрээр хяналт тавих дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний албаны ажилтнуудад ашиглахад хялбар програм хангамжийг бий болгох.

ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг хангах хууль эрх зүйн орчныг сайжруулах, түүний хэрэгжилтийг ажиглах, шаардахад иргэний нийгмийн байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэж ирэв. ННФ-аас олон жилийн туршид хэрэгжүүлж ирсэн иргэний нийгмийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны үр дүнд төсвийн ил тод байдлын талаарх хууль эрх зүйн анхан шатны мэдлэгтэй, төсвийн мэдээллийн ил тод байдлыг хянах чадавх бүхий 30 гаруй төрийн бус байгууллага төв, орон нутагт бий болж мониторингийн төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад нөлөөлөх чиглэлээр ажилладаг “Иргэд төсвөө хянана” иргэний

нийгмийн сүлжээ бүрэлдэж, үндэсний хэмжээнд төсвийн нээлттэй байдлыг бодит ажил хэрэг болгоход шахалт үзүүлж ирэв.

Шинээр бий болсон ил тод байдал, хариуцлагын механизмуудыг олон нийт болон иргэний нийгэмд танилцуулах, ашиглахад дэмжлэг үзүүлэх зорилготой сургалт, семинарыг Форумаас тогтмол зохион байгуулж ирлээ. Тухайлбал, 2017 оны 11 дүгээр сард төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын 40 гаруй төлөөлөл оролцсон зөвлөгөөн Улаанбаатар хотод зохион байгуулагдлаа. Уг зөвлөгөөнд 21 аймаг, Улаанбаатар хот, нийслэлийн 9 дүүргээс иргэний нийгмийн төлөөлөгчид оролцож

аймаг, нийслэл, дүүргүүдийн төсөв, санхүү, худалдан авалтын ил тод байдлын өнөөгийн түвшин болон, төсөв, түүний зарцуулалт ил болох нь төсвийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд бодит нөлөө үзүүлж буй эсэх талаар хэлэлцэж, төсвийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ирэх хоёр жилд явуулах үйл ажиллагааны төлөвлөлтөө хийв. Тэрчлэн төсвийн мэдээлэл цуглуулж, боловсруулах арга зүй, орон нутагт иргэний хяналт хэрэгжүүлдэг олон улсын туршлага, Нийтийн сонсголын тухай хуулийн хүрээнд төсвийн хяналтын сонсгол хийх, нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах боломжийн талаар мэдээлэл солилцож, харилцан туршлага судалсан юм.

Зөвлөгөөнд оролцсон иргэний нийгмийн байгууллагууд нь



▲ Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих иргэний нийгмийн зөвлөгөөн: Зүүн гар талаас “Иргэд төсвөө хянана” сүлжээний зохицуулагч Д.Цэрэнжав, ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, болон зөвлөгөөнд оролцогчид, 2017 оны 11 сар

Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлсэн эхний өдрөөс эхлэн ННФ-ын дэмжлэгтэйгээр нийт аймаг, нийслэл, дүүргүүдийн хэмжээнд төсвийн мэдээллийн ил тод байдалд 6 сарын туршид тасралтгүй

хяналт тавьж байсан юм. Иймд эдгээр байгууллага цаашид бүх аймаг, Улаанбаатар хот, нийслэлийн 9 дүүрэгт иргэдийн хяналтын зөвлөл байгуулан, хяналтын зөвлөлөөр дамжуулан төсвийн ил тод, хариуцлагатай

байдлыг дэмжих, нийтийн сонгол хийхийг шаардах, төсөв хөрөнгийн, үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг чиглэлд хамтран ажиллахаар болов.

“ИРГЭД ТӨСВӨӨ ХЯНАНА” ИРГЭНИЙ НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг хангахад нөлөөлөл үзүүлэх зорилгоор 2009 онд байгуулагдсан иргэний нийгмийн байгууллагуудын “Иргэд төсвөө хянана” сүлжээний үйл ажиллагааг бидний зүгээс дэмжин ажиллаж ирлээ. Уг сүлжээ орон нутгийн төсвийн мэдээллийн ил тод байдлын болон ИТХ-аас төсөв батлах хуралдаанд мониторинг хийх, судалгааны мэдээлэл цуглуулах, төсвийн мэдээллийн www.tusuv.mn сайт ажиллуулж

зэрэг үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс гадна төсвийн холбогдох хэлэлцүүлэг, семинаруудад оролцож ирлээ. Уг сүлжээнээс 2017 онд төсвийн ил тод байдал, худалдан авах ажиллагаанд иргэний нийгмийн төлөөлөл хэрхэн оролцож буйд мониторинг хийхийн зэрэгцээ сүлжээний сайтыг шинэчлэх зэрэг ажлыг хийж байна. Энэхүү мониторингийн дүн ба зөвлөмжийг төрийн ба төрийн бус байгууллагын төлөөлөлд танилцуулав. Түүнчлэн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн мониторингид 10 гаруй төрийн байгууллагыг хамруулж, цуглуулсан дүн мэдээгээрээ “Шилэн дансны ажиглалт” мэдээллийн хуудас бэлтгэн гаргаж олон нийтэд хүргэв. Түүнчлэн Цаашид “Иргэд төсвөө хянана” сүлжээний вэб сайтыг нийт иргэний нийгмийн байгууллагуудын төсвийн ажиглалт, хяналтын үндсэн сайт болгож өргөжүүлэхээр ажиллаж байна.



▲ Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих иргэний нийгмийн зөвлөгөөнд оролцогчид, 2017 оны 11 сар

Манай улс сүүлийн жилүүдэд төсвийн удирдлагыг сайжруулах чиглэлд дорвитой алхам хийхээсээ илүү төсвөө хэт тэлж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа ойр ойрхон өөрчлөлт оруулан төсвийн алдагдал, өрийн хязгаарыг нэмсээр 2017 оны байдлаар өрийн дарамтад оров. Өрийн удирдлагын тухай хуульд Засгийн газар зээлийн баталгаа гаргах, түүний эргэн төлөлтөд хяналт тавих тогтолцоог тусгасан хэдий ч энэ заалт хэрэгжихгүй байгаагаас Засгийн газар Хөгжлийн банкны гадаад зээлийг төлөх нөхцөл байдал хүрээ. Мөн Засгийн газар Хөгжлийн банкаар дамжуулан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтдаа хариуцлагагүй хандсанаас бондын эргэн төлөлт хийхэд Олон Улсын Валютын Сангаас санхүүгийн дэмжлэг авахаар болсон нь Засгийн газрын өрийн хэмжээг улам өсгөхөөр байна. Энэ нь төр засгийн зүгээс төсвийн харилцааг зохицуулж буй хуулиуд, нэн ялангуяа, Төсвийн тогтвортой байдлын тухай болон Өрийн удирдлагын тухай хуулийг мөрдөх хэрэгтэй байгааг харуулж байна.

Сүүлийн арав гаруй жилийн туршид ННФ Монгол Улсын төсвийн болон бизнесийн орчны чиглэлээрх бодлого, төлөвлөлт болон тухайн цаг үед тулгамдаж буй асуудлаар бусад байгууллага, судлаачидтай хамтран судалгаа хийж дүн, мэдээллийг бодлого боловсруулагч, олон нийтэд хүргэж ирлээ. Өнгөрсөн онд бид төсвийн төлөвлөлтийн асуудлаар уулзалт, хэлэлцүүлэг өрнүүлж Засгийн газрын өр, төлбөрийн өнөөгийн байдлын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэж ирлээ. Тэрчлэн сүүлийн жилүүдэд Засгийн газраас гаргасан бондуудын эргэн төлөлтөд хүндрэл учрах нөхцөл байдал үүсэж байгааг дурдаж байсан билээ. Энэ онд бид 2018 оны төсвийн төлөвлөлтийн талаарх мэдээлэл бэлтгэн нийтэд хүргэснээс гадна, өрсөлдөх чадвар, бизнесийн орчныг тодорхойлох ээлжит судалгааны дүнг танилцуулаа.

УЛСЫН ТӨСВИЙН ТАЛААРХ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ











Төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд төр засгийн зүгээс төсвийн төлөвлөлтийн талаарх

мэдээллийг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр, хялбаршуулан “иргэний төсөв” болгон олон нийтэд хүргэхийг олон улсын судалгааны байгууллагуудаас зөвлөмж болгодог. Харин манай улсын Засгийн газрын зүгээс иргэний төсвийг зөвхөн 2014 онд бэлтгэн гаргаж байсан бол түүнээс хойш төсвийн санал, эсхүл батлагдсан төсвийн хялбаршуулсан хувилбарыг нийтэд хүргээгүй байна. Иймээс бид Монгол Улсын 2018 оны батлагдсан төсвийг зарим салбар болон бодлогын тулгамдсан асуудлаар бүлэглэн, жирийн иргэн ойлгож мэдэхэд хялбаршуулж инфо графикууд болгон олон нийтэд хүргэлээ. Энэ нь цаашид төсвийн үйл явц дахь иргэдийн идэвх оролцоог өрнүүлэхэд хувь нэмэр оруулна хэмээн бид найдаж байна.

2018 оны төсвийг 2.4 их наяд төгрөгийн алдагдалтай баталсан нь хуримтлагдсан алдагдлын хэмжээг нэмэгдүүлж, өрийн дарамтыг өсгөв. Иймд иргэний нийгмийн зүгээс төсвийн талаар мэдээлэлтэй байж, төр засгаас төсвийн хариуцлагаа дээшлүүлэхийг шаардах нь нэн чухал байна.

2018 оны батлагдсан төсвийн талаарх цуврал инфографикууд


Монгол Улсын 2018 оны батлагдсан төсвийн төсвийн зарлага, алдагдал, өр, агаарын бохирдлыг бууруулах чиглэлд төсөвлөсөн зардал зэрэг бодлогын тулгамдсан асуудлаар болон боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж зэрэг салбараар бүлэглэн, хялбаршуулж олон нийтэд хүргэв.



2018 оны төсвийг өмнөх жилүүдийн адил ихээхэн хэмжээний алдагдалтай баталсан нь хуримтлагдсан алдагдлын хэмжээг нэмэгдүүлж, өрийн дарамтыг өсгөхөөр болсон.

БИЗНЕСИЙН ОРЧИН

Монгол Улсын өрсөлдөх чадварын оноо, зэрэглэл (2005-2017 он)




Эх сурвалж: ДЭЗФ-ын Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангууд

Улс орны хөгжилд нөлөөлөгч гол хүчин зүйлүүдийг статистик мэдээ болон тухайн орны бизнесийн удирдах ажилтнуудын санал асуулгад тулгуурлан үнэлж, дэлхийн улсуудыг өрсөлдөх чадвараар нь эрэмбэлдэг Дэлхийн өрсөлдөх чадварын жил тутмын тайлангийнхаа дүнг Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ) 9 дүгээр сард танилцуулав. Судалгааны дүнг улс орнуудын төр засаг бодлого, шийдвэртээ тусгахаас гадна, хөрөнгө оруулагчид, олон улсын хөгжлийн түншлэлийн байгууллагуудаас тухайн орны эдийн засаг, бизнесийн орчныг

үнэлэхдээ нэг гол эх сурвалж болгон авч үздэг юм. Монгол Улс 2005 оноос уг тайланд нэгдсэн ба энэ хугацаанд ННФ нь ДЭЗФ-ын түншээр 14 дэх жилдээ ажиллаж байна. Бид энэхүү тайлан дахь Монгол Улсын дүнг олон нийтэд өргөн хүрээнд танилцуулснаар судалгааны дүнг нь УИХ-аар 2016 онд батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийн биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийн тоонд багтсан талаар өмнөх тайланд дурдаж байсан билээ.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичигт улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлж эхний 70 байрт багтах зорилгыг төр засгаас дэвшүүлсэн боловч Өрсөлдөх чадварын 2017-2018 оны тайлангаар Монгол Улс судалгаанд хамрагдсан 137 орноос 101 дүгээрт эрэмбэлэгдэв.



2017-2018 оны Өрсөлдөх чадварын тайлангаар Монгол Улсын оноо өмнөх онтой харьцуулахад 0.1-ээр дээшилж 3.9 болж судалгаанд хамрагдсан 137 орноос 101 дүгээрт эрэмбэлэгдэв. Хэдийгээр төр засгаас “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичигт улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлж эхний 70 байрт багтах зорилт дэвшүүлсэн хэдий ч энэ талаар дорвитой ажил хийгдэхгүй байгааг энэхүү судалгааны дүн харуулж байна. Манай улсын институциудын чанар, хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай байдал, санхүүгийн зах зээлийн хөгжил зэрэг 6 үзүүлэлтийн оноо өмнөх оноос буурсан ба эдгээр асуудалд нэн тэргүүнд анхаарлаа

хандуулах шаардлагатай байна. Харин хөрөнгө оруулагчийн хамгаалалтын түвшин, үндэсний нийт хуримтлал, их дээд сургуульд хамрагдалт, ерөнхий боловсролын сургуулиудын интернэтийн хэрэглээ, бизнес эхлэн эрхлэхэд шаардагдах журам болон хоногийн тоо, цалин хөлс тогтоох уян хатан байдал, үүрэн холбооны интернэт хэрэглэгчдийн тоо, ажлаас халахад гарах зардал зэрэг 10 гаруй үзүүлэлтээр 140-өөд орноос эхний 50 байрт багтав.

“Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2017-2018” дахь Монгол Улсын зэрэглэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон холбогдох инфографикийг www.forum.mn сайтаас үзнэ үү.



БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР

2017 ОНД

Сүүлийн 3 жилд гаргасан хүчин чармайлтын үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах зарчим төрийн бодлого болж хуульчлагдлаа.



ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ



◀ “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн Дэд зохицуулагч Б.Болорсайхан

Н ээлттэй Нийгэм Форум 2017 онд тэгш хамруулах боловсролын бодлогын орчныг сайжруулахаар тууштай ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжиж ажиллалаа. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох болон нийгмийн үйлчилгээнд эрх тэгш хамрагдах эрхийг баталгаажуулахаар бодлогын нөлөөлөл хийж ирсэн эцэг эхчүүдийн холбоо (цаашид Холбоо гэх), хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх, бодлогын үр нөлөөтэй оролцоог бэхжүүлэх ажлаа үргэлжлүүлэв. Үүний зэрэгцээ боловсролын эрх зүйн орчныг хүүхэд эрх тэгш байх байр сууринаас харж сайжруулах хүсэл сонирхолтой төрийн бус байгууллага, судлаачдад мэдээлэл хүргэх, мэдлэгийг нь нэмэгдүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлээ.

Тэгш хамруулах боловсролын сүлжээний сургалтын үеэр Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилтыг оролцогчдод танилцууллаа. 2017 оны 7 сар ▶

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН БОДЛОГЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ

Сүүлийн хоёр жилд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг баталгаажуулсан томоохон алхмууд хийгдэв. 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2017 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг хангах Үндэсний хөтөлбөр батлагдлаа. Хууль, Үндэсний хөтөлбөрийг боловсруулахад иргэний нийгмийн байгууллагууд маш идэвхтэй оролцож, тус бүрийн асуудлаар тодорхой санал оруулахын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийтлэг хэрэгцээг хангах шинэлэг, дэвшилтэт шийдвэрүүдийг тусгаж чадсан юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах зарчим төрийн бодлого болж хуульчлагдсан нь нэг талаас

төрийн бус байгууллагуудын тууштай нөлөөллийн үр дүн, тэдний мэдлэг, чадварын илэрхийлэл юм. Нөгөө талаас, тэгш хамруулах бодлогын яриа хэлэлцүүлэгт үр нөлөөтэй оролцохын тулд төрийн бус байгууллагууд нэгэнт батлагдсан хуулийг хэрэгжүүлэхэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх экспертизтэй байх хэрэгцээ, шаардлага улам бүр тулгамдаж эхэлсэн. ННФ тэгш хамруулах боловсролын эксперт болж хөгжихөд нь түнш төрийн бус байгууллагуудаа дэмжин ажиллаж байна.

Энэ чиглэлээр бид Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны хөгжлийг дэмжиж, гишүүн эцэг эхчүүдийнхээ эрх зүйн мэдлэг,

хүүхдийн эрхийг хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. 2000 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эхэд үйлчилгээ үзүүлэн ажиллаж ирсэн Холбоо нь 2015 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн үйлчилгээнд тэгш хамрагдах эрхийг хамгаалах байгууллага болох, үүний тулд бодлогын нөлөөллийн чадавхаа бэхжүүлэх хэрэгцээг илэрхийлсний дагуу ННФ нь байгууллагын хөгжлийн тэтгэлэг олгосон билээ. Үйлчилгээний байгууллагаас бодлого, хүний эрхийг хамгаалагч болоход чиглэсэн Холбооны дунд хугацааны Стратегийг 2016 онд боловсруулан, 2017 онд эрчимтэй хэрэгжүүлж эхэлсэн байна. 2017 оны үйл



ажиллагааны үр дүнд тус Холбоо нь дотоод зохион байгуулалт, шийдвэр гаргалт, төлөвлөлтөө сайжруулж, хөтөлбөр хариуцсан ажилтнуудаа мэргэшүүлэх чиглэлээр ажиллалаа. Үүний үр дүнд Холбооны гишүүн эцэг эхчүүд хууль ашиглан асуудлаа шийдүүлэх нь нэмэгдэж, Холбооны Гүйцэтгэх захирал хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийг төлөөлж бодлогын үйл явцад идэвхтэй оролцох болсон байна. ННФ-ын зүгээс Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоонд арга зүйн дэмжлэг үзүүлж, гишүүн эцэг эхчүүдийг сургалтуудад хамруулан, хөтөлбөрийн ажилтнууд болон Холбооны Гүйцэтгэх захирлыг чиглүүлж, зөвлөгөө өгч ажиллалаа.

2017 оны эцсээр гарсан зарим үр дүнг тоймловол Холбооны гишүүн эцэг эхчүүд хуулийг амьдралдаа идэвхтэй ашиглаж эхэлсэн байна. Ерөнхий зөвлөгөө өгөх, туршлагаа хуваалцах маягаар ажиллаж ирсэн Зөвлөх эцэг эхийн

хөтөлбөр нь хариуцсан эрх зүйч мэргэжлийн ажилтантай болж түүний удирдлага дор боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарын эрх зүйн боломжуудын талаар мэдээлэл, зөвлөгөө өгдөг болжээ. Хөтөлбөр нь сард нэг удаа багаар уулзаж асуудлаа ярилцахаас эхэлж байсан бол одоо бүлгээр болон ганцаарчилсан байдлаар, мөн утсаар, онлайнгаар гэх мэт олон хэлбэрээр зөвлөгөө өгч ажиллаж байна. Зөвлөх эцэг эхтэй ажилласнаар хүүхдээ цэцэрлэгт хамруулахаар шийдсэн, хуулийн заалтад үндэслэн шаардлага тавьж хорооны сургуульд хүүхдээ элсүүлсэн, мөн орон нутгаас шилжиж ирэнгүүтээ баримт бичгээ бүрдүүлж хүүхдээ нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан тухай гишүүн эцэг эхчүүд ярьж байна.

Тэрчлэн, хүүхдийн эрхийн зөрчлийн хөтөлбөр шинээр бий болгосон нь Зөвлөх эцэг эхийн хөтөлбөртэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийтийн үйлчилгээ, ялангуяа

боловсролын үйлчилгээнд хамруулахгүй байгаа тохиолдлуудыг бүртгэн судалж, хариуцсан албан тушаалтанд мэдээлж шийдүүлэх хүсэлт гаргахын зэрэгцээ бодлогын нөлөөлөлд ашиглаж байна. Уг хөтөлбөр нь Удирдах Зөвлөлийн гишүүдийг дайчлан хамтран ажилладгаараа онцлогтой.

Холбоо нь нийгмийн салбарт танигдсан, хүлээн зөвшөөрөгдсөн иргэний нийгмийн байгууллага болж байна. Холбооны Удирдах Зөвлөл, хөтөлбөрийн ажилтнуудын үүрэг, оролцоо тодорхой болж оролцоо нэмэгдсэнээр Гүйцэтгэх захирал нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийг төлөөлж нийгмийн үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцох боломж бүрджээ. 2017 оноос Холбооны Гүйцэтгэх захирал С. Сэлэнгэ Ерөнхий сайдын дэргэдэх, мөн нийслэлийн, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлүүдэд орж ажиллаж байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ

Түгээмэл Хөгжил Төв ТББ-ын чадавхыг бэхжүүлэх дэмжлэг хоёр дахь жилдээ үргэлжлэв. Уг байгууллага нь 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрхийг хүндэтгэх, хангах тухай заалт оруулахад хүчтэй

нөлөө үзүүлсэн. 2017 онд уг байгууллагын дунд хугацааны Стратеги шинэчлэгдэж бие даан амьдрах эрхийн хэрэгжилтийг хангуулах, чанартай боловсролыг хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхдэд хүртээмжтэй болгоход нөлөөлөх зорилтыг дэвшүүлжээ.

Түгээмэл хөгжил төв нь байгууллагын чадавх бэхжүүлэх дэмжлэгийн хүрээнд байгууллагын дунд хугацааны Стратеги боловсруулж “Бие даан амьдрах эрх”, “Тэгш хамруулах боловсрол” гэсэн хоёр хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн

зохион байгуулж байна. 2017 онд Стратегиа хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн чадавх нэмэгдүүлэх сургалтууд хийж, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг төлөвлөх, явцыг үнэлэх уулзалтуудыг долоо хоног бүр хийж хэвшиж байгаа ба үүнд ажилтнуудаас гадна хөгжлийн бэрхшээлтэй сайн дурын гишүүн залуучуудыг оролцуулж, давхар мэдээллээр хангах стратеги баримтлан ажиллаж байна. Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах стратеги боловсруулан, сэтгүүлчидтэй уулзалт хийхийн зэрэгцээ гурван удаагийн радио ярилцлага хийж, 25 минутын нэвтрүүлэг бэлтгэн МҮОНРТ-

ийн сувгаар цацаж олон нийтэд хүргэлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг сургах Тэгш хамруулах боловсролын хөтөлбөр шинээр бий болгож, дөрвөн хүнтэй баг бүрдүүлжээ. Уг хөтөлбөр нь 2017 онд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг сургах чиглэлд төвлөрч Монгол улс дахь Германы хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэгтэйгээр Мэргэжлийн Боловсролын Сургалт, Үйлдвэрлэлийн төвүүдэд тэгш хамран сургах боловсролыг нэвтрүүлэх гарын авлага боловсруулан, багш нарт

сургалт хийжээ. Мөн Дархан хотын Уурхай, эрчим хүчний политехникийн коллежид хөгжлийн бэрхшээлтэй иргэн суралцах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сургууль, дотуур байрны дэд бүтцийн үнэлгээ хийх, багш, ажилтнуудад тэгш хамрах боловсролын талаар мэдээлэл өгөх сургалт зохион байгуулсан байна.

Түгээмэл Хөгжил төв ТББ-ын Гүйцэтгэх захирал Я.Авирмэд нь БСШУСЯ-нд Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусын боловсролын орон тооны бус дэд зөвлөлд орж ажиллаж байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ АСУУДЛААР АЖИЛЛАЖ БУЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ

ННФ нь төрийн бус байгууллагад урт хугацааны дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ тэгш хамруулах боловсролын чухал бүрдэл механизмуудыг тайлбарлах, шинээр батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн Сурч боловсрох эрх хэсгийг нарийвчлан судлах, бүх нийтийн чанартай боловсролд төвлөрсөн Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилтыг танилцуулах зэрэг сургалт, семинаруудыг зохион байгуулав. Дээрх үйл ажиллагаануудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн, боловсролын болон залуучуудын байгууллагуудыг татан

оролцуулахыг хичээлээ.

Энэ онд түнш байгууллагуудын гадаад харилцааг бэхжүүлж, туршлага судлах боломжоор хангахад анхаарав. Түгээмэл Хөгжил Төв ТББ нь Дэлхийн бие даан амьдрах сүлжээний АНУ-д болсон олон улсын уулзалтад оролцож, сүлжээний гишүүн байгууллагаар элсэв. Мөн АНУ-ын ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй төвийн үйл ажиллагаатай танилцаад зогсохгүй залуучуудын хөгжил, боловсролыг дэмжих чиглэлээр хамтран ажиллах хэлцэл байгуулаад ирлээ. Дэлхийн Бие даан амьдрах сүлжээний

2018 оны уулзалтыг Монгол Улсад зохион байгуулах боломжийг Сүлжээний удирдах багтай хамтран судалж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Монголын Дауны Холбоо, Монголын Аутизмын Холбоо зэрэг байгууллагуудыг боловсролын нөлөөлөлд татан оролцуулах зорилготой уулзалтууд хийж, хамтран хэрэгжүүлж болох үйл ажиллагаагаа судлан ярилцахын зэрэгцээ тэгш хамруулах боловсролын бодлого, хэрэгжилтэд нөлөөлөх Хятадын эцэг эхчүүдийн холбоодын туршлагыг судлах аялал хийхээр бэлтгэлээ хангаж байна.

ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЛИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ



Өсвөр насны хүүхэд, залуучуудын дунд үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл нэлээд байдаг ч судалж тогтоосон нь бага, бууруулах болон урьдчилан сэргийлэх системтэй арга хэмжээ дутмаг байна. 2017 онд ННФ-ын дэмжлэгтэйгээр залуучуудын гурван төрийн бус байгууллагын хийсэн судалгаагаар сургуулийн орчинд үе тэнгийн дээрэлхэлт их байгаа ч үүнийг хэнд хандаж таслан зогсоох талаар мэдээлэл алга байгаа нь харагдсан юм. Демокрейти, Хөөрхөн зүрхнүүдийн аян, Өөрчлөлтийн салхи ТББ-ууд 2017 онд ахлах

ангийн сурагчид, сургууль дөнгөж төгссөн залуучуудын дунд хүчирхийлэл, дээрэлхэлттэй холбоотой судалгаа хийлээ. 15-19 насны залуучууд оролцсон асуулга, ярилцлагын дүнгээс харахад охидын дунд элдэв цуу яриа тараах, гадуурхах, нэр хоч өгөх, үсдэж зодох, өмссөн хувцас зэргээр ялгаварлах, доромжлох хэлбэрийн дээрэлхэлт их байдаг ажээ. Түүнчлэн охид хормойг нь сөхөх, элдэв янзаар хоргоох, биед нь хүрэх зэргээс их эмзэглэдэг ба бэлгийн хүчирхийлэлд өртсөн хоёр ч тохиолдол гарсан ч эцэг эх, багшдаа хэлээгүй байна. Харин

◀ “Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь” судалгааны тайлангийн уулзалтын үеэр (Улаанбаатар хот, 2017 он)

Хөтөлбөрт оролцогч талууд
зүүн гар талаас
МУБИС-ийн Нийгмийн ажлын
арга зүйн тэнхимийн эрхлэгч
Т.Цэндсүрэн
Демокрейти Залуусын төвийн
захирал Б.Энхжаргал
АШУУИС-ийн НЭМС-ийн Зан
үйл судлалын тэнхимийн
багш Т.Жаргалсайхан
ШУТИС-ийн Бизнес,
Хүмүүнлэгийн сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн
эрхлэгч С.Туяа ▶

хөвгүүдийн дунд зодох, мөнгө нэхэж дарамтлах, айлган утас болон эд зүйлийг авах хэлбэрээр дээрэлхэлт илэрдэг ба хүйсийн ялгаагүй цахим дээрэлхэлт мөн их байдаг гэжээ.

Дээрэлхэх үйлдэл нь сургуулийн дотор болох нь ховор, тэр тусмаа багш нарын нүдэн дээр болоод байдаггүй учир багш нар дээрэлхэлт гардаггүй гэж ойлгодог. Их завсарлагаар, хичээл дөнгөж тарангуут, сургуулийн хараа хяналтгүй булан, хонгил, дээврийн хөндий зэрэг газар ийм явдал гарч байдгийг сурагч бүр мэддэг байна. Хамгийн харамсалтай нь, багш нар хүүхдэд хоч өгөх, загнаж доромжлох, чимхэх, толгой руу нь цохих зэргээр харьцдаг ба багш, ахлах ангийнхан үлгэр жишээ байх юм бол хүүхдүүд даган дуурайж, сургуулийн уур амьсгал эерэг болно гэж тэд үзэж байна. Дээрэлхэлт, хүчирхийллийг багш

нар таслан зогсоох боломжтой ч тэд арга хэмжээ авдаггүй гэж хүүхдүүд ярьжээ.

Бусад оронд сургууль дээрх үе тэнгийн дээрэлхэлтийг судалж урьдчилан сэргийлэх журам, хөтөлбөр батлан, хэрэгжүүлэхийг сургууль бүрээс төрийн бодлогоор шаарддаг бөгөөд журмын хэрэгжилтийг сургуулийн захирал хариуцан хэрэгжүүлдэг туршлага байна. Хичээлийн жилийн эхэнд болон эцэст дээрэлхэлтийн талаар судалгаа авч, өөрийн онцлогт тохирсон арга хэмжээ сонгон хэрэгжүүлэхийн дээр судалгааны дүнгээр дээрэлхэлтийн өсөлт, бууралтыг ажиглаж байдаг. Сургуулиудын мэдээллийг нэгтгэн, үндэсний хэмжээнд сурагчдын эрүүл аюулгүй орчинд сурч, хөгжих нөхцөл хэр хангагдаж байгаад үнэлгээ хийх боломж олгосон мэдээллийн бааз бүрдүүлдэг нь энэ тогтолцооны давуу тал

юм. Манай улс энэ туршлагыг нэвтрүүлснээр Боловсролын тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиудын хүүхэд, залуучуудыг амьдрах ухааны ур чадварт сурган, эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих боломжийг хангах тухай заалтууд бүрэн хэрэгжих боломжтой болох юм.

Бид 2014 оноос залуу хүмүүс, ялангуяа өсвөр насны хүүхдүүдийн дундах хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх дотоодын мэдлэг, чадавхыг бий болгохоор нийгмийн ажилтан, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, залуучуудын төрийн бус байгууллагатай түншлэн ажиллаж ирэв. Хүүхэд, залуучуудтай ажилладаг нийгмийн салбарын мэргэжилтэн бэлтгэдэг 3 их сургууль, залуучуудын төрийн бус байгууллагууд хамтран ННФ-ын дэмжлэгтэйгээр өсвөр насны хүүхэд, залуучуудын дундах дээрэлхэлт, хүчирхийллийг




урьдчилан сэргийлэх бодлого, нөхцөл байдлын хяналтын тогтолцоотой болох санаачилгыг манлайлан ажиллаж байна. 2014-2017 онд эдгээр байгууллагын хүчин чармайлтаар үе тэнгийн дээрэлхэлтийн нөхцөл байдал, түүнийг судлах болон урьдчилан сэргийлэх аргачлалуудтай болж, нийгмийн ажлын мэргэжил эзэмшин төгсөж байгаа болон одоо ажиллаж байгаа мэргэжилтний сургалт, оюутны дадлага, дипломын ажил, багш нарын судалгааны бүтээлүүд гаран, багшийн мэргэжил арга зүйн байгууллагууд, хүүхэд хамгааллын байгууллагуудтай хамтран ажиллах боломж нээгдлээ. Тэрчлэн ахлах ангийн сурагчид, тэдний эцэг эх, олон нийтэд өсвөр насны хүүхдийн дундах хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх тухай мэдээлэлтэй болж байна.

2017-2018 оны хичээлийн жилд АШУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль, ШУТИС-ийн Бизнес, Хүмүүнлэгийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхим нь бакалаврын сургалтын хөтөлбөртөө залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх 2-3 кредитийн агуулга оруулан зааж эхлээд байна. 2017 онд МУБИС-ийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхим манай хөтөлбөрт шинээр нэгдэж, сургуулийн нийгмийн ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн чадавхыг бий болгохоор ажиллаж эхлээд байна. Нийгмийн ажилтан

бэлтгэдэг 17 их дээд сургуулийн дотроос төрийн өмчит уг гурван сургууль нь нийт нийгмийн ажилтны 80 гаруй хувийг бэлтгэн төгсгөдөг ба хороо, сургуулийн нийгмийн ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтыг мөн хэрэгжүүлдэг тул ННФ-ын дэмжлэгийн хүрээнд бий болгосон мэдлэг, чадавхаа өргөн хүрээнд тараан түгээх, хуваалцах боломжтой юм.

АШУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль 2017 онд Нийслэлийн Боловсролын газартай хамтран Улаанбаатар хотын ЕБС-ийн 131 нийгмийн ажилтанд сургалт хийсэн нь маш үр дүнтэй болж, тэд ажлын байрандаа хөтөлбөр, үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлснээс гадна тэдгээр сургуулийн захирал, сургалтын менежерүүдээс сургалт авах хүсэлт ч ирсэн байна. 2017 онд уг сургуулийн багш, оюутнууд 6 судалгаа, эрдэм шинжилгээний 10 нийтлэл гаргаж, бусад их дээд сургуульд тараагаад байна. Мөн өөрсдийн боловсруулан ашиглаж байгаа сургалтын хөтөлбөр, унших материал, багшийн гарын авлагыг нийгмийн ажилтан бэлтгэдэг 10 сургуульд хүргэж, төрийн өмчийн 4, хувийн 3 их дээд сургуулийн нийгмийн ажлын тэнхимийн багш нарт сургууль дээр нь сургалт, танилцуулга хийжээ. 2017 онд дуусгавар болж байгаа 2 жилийн хугацаатай тэтгэлгийн хүрээнд уг тэнхим Өсвөр насны хүүхэд, залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан



Нотлох баримтын тойм

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас 2015 онд хэвлэн гаргасан *“Preventing youth violence: an overview of the evidence”* гарын авлагыг Нээлттэй Нийгэм Форум 2017 онд албан ёсны зөвшөөрөлтэйгээр орчуулан, хэвлэж нийтийн хүртээл болгов.

сэргийлэх албан ёсны сургалтын хөтөлбөр боловсруулж түүнийгээ нийгмийн ажилтан бэлтгэх бакалаврын түвшний сургалт, дадлагын ажилд нэвтрүүлсэн анхдагч нь юм.

ШУТИС-ийн Нийгмийн ажлын тэнхим 2017 онд хорооны нийгмийн ажилтнуудад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэв. Бэлтгэл ажлын хүрээнд “Өсвөр насныхны дундах дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх нийгмийн ажил” нэртэй нийт 8 бүлэгтэй сургалтын гарын авлага, хөтөлбөр боловсруулж хэвлүүлсэн нь энэ сэдвээр уншиж судлах материал бага байгаа үед маш хэрэгтэй эх сурвалж болов. Хэвлэсэн материалаа тараан түгээхийн зэрэгцээ Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүдийн хүүхэд хамгааллын хамтарсан баг, 265 нийгмийн ажилтан хамруулсан 3 өдрийн сургалт хийсэн нь амжилттай болжээ. Сургалтаар өсвөр насны хүүхдийн дундах хүчирхийлэл, дээрэлхэлтийн тухай ойлголт өгч, таньж илрүүлэх хоёр хэрэглэгдэхүүн, урьдчилан сэргийлэхэд ашиглаж болох гурван хөтөлбөрийг танилцуулсан ба сургалтын эцэст жижиг төслийн уралдаан зарлажээ. Уралдаанд шалгарсан Сонгинохайрхан дүүргийн 18

дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 20, 21 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 2, 27 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо тус бүр ШУТИС-ийн багш нарын зөвлөгөө дэмжлэгтэйгээр төслөө хэрэгжүүлж байна. Сонгино Хайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрууд уг сургалтыг дэмжиж хорооны нийгмийн ажилтнуудаа хамруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан нь энэ санаачилгыг амжилттай хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүллээ.

2017 онд МУБИС-ийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхимтэй шинээр түншлэн, маш идэвхтэй хамтран ажиллаж эхлээд байна. Уг тэнхимийн багш нар өмнөх туршлагаудыг нэгтгэн сургуулийн нийгмийн ажилтнаар бэлтгэгдэж байгаа болон ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд хүргэхээс гадна 30-40 ЕБС-д урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн туршлага бий болгох, үндэсний хэмжээний бодлогын нөлөөллийн ажлыг манлайлан хэрэгжүүлэх юм. Ялангуяа МУБИС-ын нийгмийн ажлын арга зүйн тэнхим нь сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх бодлого, журам боловсруулах чиглэлээр БСШУСЯ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Багшийн

мэргэжил дээшлүүлэх институт зэрэг төрийн захиргааны болон сургалтын байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна.

2017 онд ННФ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран, олон нийтийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ажиллалаа. Өсвөр насны хүүхдэд чиглэсэн контент бий болгож байгаа Yolo.mn вэб сайттай хамтран 1 сарын мэдээллийн аян зохион байгуулж, үе тэнгийн дээрэлхэлтийн тухай богино видео мэдээ, постер цувралаар бэлдэж гаргахын зэрэгцээ ахлах ангийн сурагчдын дунд эргэцүүлэл эссе, өсвөр насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн захидал, залуучуудын төрийн бус байгууллагуудын судалгааны мэдээ зэргийг олон нийтэд хүргэлээ.

Өсвөр насны хүүхэд, залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгааны болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хийж байгаа энэ ажил Боловсролын тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиудад орсон хүүхэд, залуучуудын эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих боломжийг хангах тухай заалтуудыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр болох юм.



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2017 ОНД

100 гаруй төрийн
бус байгууллага, хувь
хүнд **970 гаруй сая**
төгрөгийн тэтгэлэг
олгожээ.



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2017 онд нийт 1,608,000 ам.долларын төсөвтэй ажилласан ба үүний \$ 1,580,000 нь Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Соросын сангийн сүлжээний хөтөлбөрүүдээс, \$ 15,000 нь LOGIN-оос, \$ 12,800 нь бусад донор байгууллагаас санхүүжигдсэн болно. Төсвийн зарцуулалтыг доорх хүснэгтэд харуулав.

НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР			
Хүний эрх	-	39,902	39,902
Эрх зүйн шинэчлэл	26,902	80,389	107,291
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	28,868	55,758	84,626
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь	45,825	98,976	144,801
Сонгууль, улс төрийн санхүүжилт	35,086	70,145	105,231
Төрийн ил тод хариуцлагатай байдал		-	-
Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм	23,491	13,624	37,115
Иргэний нийгмийн байгууллагуудын тогтвортой үйл ажиллагааг дэмжих нь	24,421	236,582	261,003
Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь	51,850	5,637	57,487
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР			
Олборлох салбарын засаглал	47,193	67,804	114,997
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	11,354	66,740	78,094
Бизнесийн орчин		7,095	7,095
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР			
Тэгш хамруулах боловсрол	77,067	18,463	95,530
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь	25,777	14,161	39,938
ЗАХИРГАА		406,263	406,263
НИЙТ ДҮН	397,834	1,181,539	1,579,373

ТЭТГЭЛГИЙН ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Байгууллагад олгосон	Хувь хүнд олгосон	Нийт зардал
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР			
Хүний эрх	-	-	-
Эрх зүйн шинэчлэл	26,902	-	26,902
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	28,868	-	28,868
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь	28,522	17,303	45,825
Сонгууль, улс төрийн санхүүжилт	27,831	7,255	35,086
Төрийн ил тод хариуцлагатай байдал	-	-	-
Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм	23,491	-	23,491
Иргэний нийгмийн байгууллагуудын тогтвортой үйл ажиллагааг дэмжих нь	24,421	-	24,421
Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь	51,850	-	51,850
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР			
Олборлох салбарын засаглал	45,883	1,310	47,193
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	11,354	-	11,354
Бизнесийн орчин	-	-	-
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР			
Тэгш хамруулах боловсрол	77,067	-	77,067
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь	25,777	-	25,777
ЗАХИРГАА			
НИЙТ ДҮН	371,966	25,868	397,834

2017 ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ

\$ доллар

д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, хувь хүн	Төрөл	Тэтгэлгийн дүн
1	Улаанбаатар	Түгээмэл хөгжил	ТББ	\$ 5,067
2	Булган	Гэрэлт ирээдүйн оршихуй	ТББ	\$ 1,009
3	Дархан-Уул	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	ТББ	\$ 1,009
4	Дорнод	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$ 1,008
5	Завхан	Завхан аймгийн ахмад мэргэжилтний холбоо	ТББ	\$ 1,008
6	Орхон	Төр-Иргэн түншлэл	ТББ	\$ 1,129
7	Өвөрхангай	Эх нутаг хөгжил төв	ТББ	\$ 1,129
8	Өвөрхангай	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$ 1,129
9	Увс	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$ 1,008
10	Хөвсгөл	Сүүн тахилт	ТББ	\$ 920
11	Хэнтий	Хэнтий аймгийн Ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$ 1,129
12	Улаанбаатар	МИДАС	ТББ	\$ 2,073
13	Улаанбаатар	Глоб Интернэйшнл	ТББ	\$ 6,848
14	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	ТББ	\$ 12,752
15	Дундговь	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$ 1,838
16	Дархан-Уул	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$ 2,364
17	Дархан-Уул	Орхон 21-р зуун	ТББ	\$ 1,471
18	Өвөрхангай	Орон нутгийн санаачилга	ТББ	\$ 1,448
19	Төв	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$ 1,655
20	Увс	Эрх зүйн зөв хөтөч	ТББ	\$ 1,223
21	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$ 3,663
22	Улаанбаатар	Г.Даваадорж	Иргэн	\$ 1,310
23	Улаанбаатар	Иргэд төсвөө хянана	ТББ	\$ 11,354
24	Улаанбаатар	Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд	ТББ	\$ 6,157
25	Архангай	Архангай аймгийн Оюутан залуучуудын нэгдсэн холбоо	ТББ	\$ 614
26	Баян-Өлгий	Баян-Өлгий аймгийн Ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$ 614
27	Баянхонгор	Баянхонгор аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо	ТББ	\$ 639
28	Булган	Булганы мэдээ сонин	ТББ	\$ 639

д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, хувь хүн	Төрөл	Тэтгэлгийн дүн
29	Говь-Алтай	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны Говь-Алтай аймгийн салбар зөвлөл	ТББ	\$ 639
30	Говьсүмбэр	Хотол Чойр	ТББ	\$ 614
31	Дархан-Уул	Орхон 21-р зуун	ТББ	\$ 639
32	Дорноговь	Гал голомт үндэсний хөдөлгөөн	ТББ	\$ 614
33	Дорнод	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$ 639
34	Дундговь	БОНӨБ- Эрдэнэ холбоо	ТББ	\$ 639
35	Завхан	Завхан аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөл	ТББ	\$ 639
36	Орхон	Орхон аймгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг	ТББ	\$ 639
37	Өвөрхангай	Эх нутаг хөгжил төв	ТББ	\$ 639
38	Өмнөговь	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$ 639
39	Сүхбаатар	Сэтгэшгүй Оюун далай	ТББ	\$ 614
40	Сэлэнгэ	Сэлэнгэ Итгэл АОЭХ	ТББ	\$ 614
41	Төв	Төв аймгийн Ажил олгогч эздийн бизнес холбоо	ТББ	\$ 639
42	Увс	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$ 639
43	Ховд	Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	ТББ	\$ 639
44	Хөвсгөл	Хөвсгөл далай ээж нийгэмлэг	ТББ	\$ 639
45	Хэнтий	Хэнтий аймгийн ҮЭХолбоо	ТББ	\$ 614
46	Төв	Энх Ногоон	ТББ	\$ 2,792
47	Өвөрхангай	Орон нутгийн санаачилга	ТББ	\$ 1,330
48	Улаанбаатар	Сайн тус ТББ	ТББ	\$ 2,832
49	Өмнөговь	Өмнөговь аймгийн Эмэгтэйчүүдийн холбоо	ТББ	\$ 1,932
50	Улаанбаатар	Экологи Өв соёл нийгэмлэг	ТББ	\$ 2,766
51	Улаанбаатар	Хууль зүйн үндэсний хүрээлэн	Төрийн	\$ 12,956
52	Дундговь	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$ 2,502
53	Булган	Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны Булган аймаг дахь салбар	ТББ	\$ 2,341
54	Сүхбаатар	Жанжны нутаг	ТББ	\$ 2,482
55	Улаанбаатар	Ц.Одонжав	Иргэн	\$ 2,131
56	Улаанбаатар	Т.Энхбулгантамир	Иргэн	\$ 2,142

д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, хувь хүн	Төрөл	Тэтгэлгийн дүн
57	Улаанбаатар	Ж.Бариширсүрэн	Иргэн	\$ 2,379
58	Улаанбаатар	Б.Сарантуяа	Иргэн	\$ 2,379
59	Улаанбаатар	Г.Цэцгээ	Иргэн	\$ 2,379
60	Улаанбаатар	Шинэ хамтрал	ТББ	\$ 1,479
61	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$ 1,188
62	Орхон	Эрдэнэт хүмүүний эв нэгдэл	ТББ	\$ 966
63	Дархан-Уул	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$ 1,240
64	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачилга	ТББ	\$ 1,064
65	Улаанбаатар	Хил хязгааргүй алхам	ТББ	\$ 1,575
66	Улаанбаатар	Онол арга	ТББ	\$ 898
67	Улаанбаатар	Оновчтой хөгжил	ТББ	\$ 318
68	Улаанбаатар	Хөгжлийн академи	ТББ	\$ 2,264
69	Улаанбаатар	Хүртээмжтэй хөгжил хүрээлэн	ТББ	\$ 1,534
70	Дархан-Уул	Сургалт судалгаа хөгжлийн төв	ТББ	\$ 821
71	Улаанбаатар	Шинэ суурьшил эрүүл аюулгүй орчин	ТББ	\$ 2,808
72	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$ 3,622
73	Улаанбаатар	Онон Улз голынхон хөдөлгөөн	ТББ	\$ 4,390
74	Улаанбаатар	Хил хязгааргүй алхам	ТББ	\$ 4,008
75	Улаанбаатар	Түгээмэл эрх хөгжил төв	ТББ	\$ 3,896
76	Улаанбаатар	Их бага Баян шарга сан	ТББ	\$ 4,369
77	Улаанбаатар	Нийтийн эрх ашгийн хуульчдын санаачилга	ТББ	\$ 3,807
78	Улаанбаатар	Чингэлтэй дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо	ТББ	\$ 2,846
79	Улаанбаатар	Утааны эсрэг аав ээжүүд	ТББ	\$ 813
80	Говь-Алтай	Говь -Алтай аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал	Төрийн	\$ 1,244
81	Улаанбаатар	С.Насанжаргал	Иргэн	\$ 2,445
82	Улаанбаатар	Ч.Гангэрэл	Иргэн	\$ 2,405
83	Улаанбаатар	О.Сүхээ	Иргэн	\$ 2,405
84	Улаанбаатар	С.Энхцэцэг	Иргэн	\$ 2,946
85	Улаанбаатар	Ж.Бариширсүрэн	Иргэн	\$ 2,946
86	Улаанбаатар	Хууль зүйн туслалцааны төв	Төрийн	\$ 15,567

д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, хувь хүн	Төрөл	Тэтгэлгийн дүн
87	Улаанбаатар	Байгаль орчин эрүүл мэнд төв	ТББ	\$ 16,614
88	Улаанбаатар	Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо	ТББ	\$ 1,059
89	Улаанбаатар	Зүүн бүсийн хүний эрхийн төв	ТББ	\$ 425
90	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$ 19,154
91	Багануур	Багануур дүүргийн эмэгтэйчүүдийн ТББ-уудын сүлжээ	ТББ	\$ 1,025
92	Улаанбаатар	Ус Ургамал Амьдрал	ТББ	\$ 2,740
93	Улаанбаатар	Ил тод байдал сан	ТББ	\$ 16,081
94	Улаанбаатар	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо	ТББ	\$ 42,000
95	Улаанбаатар	Монгол Улсын Боловсролын Их Сургууль	Сургууль	\$ 25,777
96	Улаанбаатар	Эрх зүйн соёл	ТББ	\$ 1,558
97	Улаанбаатар	Оюуны Инноваци	ТББ	\$ 2,744
98	Улаанбаатар	Хөгжлийн академи	ТББ	\$ 987
99	Улаанбаатар	Эрх зүйн хөгжлийн төлөө	ТББ	\$ 2,349
100	Улаанбаатар	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	ТББ	\$ 4,108
101	Дундговь	Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сан	ТББ	\$ 802
102	Дорнод	УТБАкадеми Дорнод салбар	ТББ	\$ 2,308
103	Дорнод	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$ 1,355
104	Дархан-Уул	Орхон 21-р зуун	ТББ	\$ 1,158
105	Улаанбаатар	Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо	ТББ	\$ 1,020
106	Улаанбаатар	Дауны синдромын холбоо	ТББ	\$ 30,000
107	Улаанбаатар	Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд	ТББ	\$ 4,070
108	Улаанбаатар	Ардчиллын боловсрол төв	ТББ	\$ 4,070
109	Улаанбаатар	Сонгогчийн боловсрол бөв	ТББ	\$ 4,070
110	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачилга	ТББ	\$ 4,070
111	Улаанбаатар	Хил хязгааргүй алхам	ТББ	\$ 4,070
112	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$ 4,070
НИЙТ				\$ 397,834

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, АЖИЛТНУУД

Нээлттэй Нийгэм Форумын Удирдах Зөвлөлийн гишүүд

Г. Уранцоож	УЗ-ийн дарга, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн
Ж. Үнэнбат	УЗ-ийн гишүүн, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын гүйцэтгэх захирал
Ч. Хашчулуун	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ЭЗС-ийн багш
Ч. Лодойравсал	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ХШУИС-ийн багш
О. Энхтуяа	УЗ-ийн гишүүн, Дэ Нэйчэр консерванси ТББ-ын захирал
П. Наранбаяр	УЗ-ийн гишүүн, Шинэ Монгол дунд сургуулийн захирал
О. Мөнхсайхан	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ХЗС-ийн багш

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

П. Эрдэнэжаргал	jargal@forum.mn
-----------------	-----------------

Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд

П. Бадамрагчаа	Засаглалын хөтөлбөрийн менежер	badmaa@forum.mn
А. Гэрэлмаа	Боловсрол, Нийгмийн бодлогын хөтөлбөрийн менежер	gerelmaa@forum.mn
Д. Оюунбадам	Эдийн засгийн хөтөлбөрийн менежер	oyunbadam@forum.mn
Б. Хишигсайхан	Засаглалын хөтөлбөрийн менежер	khishgee@forum.mn
Д. Энхцэцэг	Засаглалын хөтөлбөрийн менежер	enhee@forum.mn
Д. Эрдэнэчимэг	Засаглалын хөтөлбөрийн менежер	chimgee@forum.mn
О. Сэлэнгэ	Хөтөлбөрийн туслах ажилтан	selenge@forum.mn
У. Энхцэцэг	Хөтөлбөрийн туслах ажилтан	enkhtsetseg@forum.mn
Б. Үүрийнтуяа	Хөтөлбөрийн туслах ажилтан	fellowship@forum.mn
Д. Балжид	Мэдээллийн менежер	baljid@forum.mn
Б. Мөнхгэрэл	Сэтгүүлч	munkhgerel@forum.mn
Д. Жавхлан	Санхүүгийн захирал	javkhlan@forum.mn
Ж. Алтанчимэг	Нягтлан бодогч, тэтгэлгийн менежер	altai@forum.mn
Э. Сайнтүвшин	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	sainaa@forum.mn
Б. Амгалан	Захирлын туслах	osf@forum.mn
Б. Баатар	Захиргааны ажилтан	baatar@forum.mn
Г. Цэдэвхүү	Захиргааны ажилтан	tsedev@forum.mn
Б. Бат-Эвлэл	Захиргааны ажилтан	

Нийтлэг И-мэйл: osf@forum.mn
